

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2021 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
7 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР /ЛХАГВА ГАРАГ/-ИЙН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
ТОВЬЁГ**

№	Хэлэлцсэн асуудал	Хуудасны дугаар
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-6
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	7-53
	1. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай анхдагч хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт нарын 15 гишүүн 2021.07.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	9-25
	2. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2021.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	25-29
	3. “Монгол Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	29-33
	4. Төрийн албаны зөвлөлийн 2019, 2020 оны үйл ажиллагааны тайлан	33-53

**Монгол Улсын Их Хурлын 2021 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 7 дугаар сарын 07-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Мөнхбат ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан Засгийн газраас Гамшгаас хамгаалах тухай хуулийн дагуу өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар Байнгын хорооны хуралдааныг цахим хэлбэрт шилжүүлж, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Мөнхбат, Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Ж.Ганбаатар, Г.Занданшатар, М.Оюунчимэг, Б.Пүрэвдорж, Н.Энхболд нар “Жанжин Д.Сүхбаатар” танхимаас, бусад гишүүд MyParliament программ болон цахим хуралдааны программыг ашиглан Байнгын хорооны хуралдаанд цахимаар оролцов.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн цахим хуралдааны программын ирцэд бүртгүүлж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 10 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ж.Батсуурь, Л.Оюун-Эрдэнэ, Ж.Эрдэнэбат.

Нэг.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай анхдагч хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт нарын 15 гишүүн 2021.07.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн профессор, Хууль зүйн доктор О.Мөнхсайхан “Жанжин Д.Сүхбаатар” танхимаас оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Болормаа, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Бямбадулам, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, реферет Э.Баттогтох, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга

Б.Эрдэнэбилэгт, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга С.Янжинхорлоо, Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт “Жанжин Д.Сүхбаатар” танхимаас танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Ж.Сүхбаатар нарын цахимаар тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Болормаа, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн профессор, Хууль зүйн доктор О.Мөнхсайхан нар “Жанжин Д.Сүхбаатар” танхимаас нар хариулж, тайлбар хийв.

Төслийн талаар Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Ц.Мөнхцэцэг нар “Жанжин Д.Сүхбаатар” танхимаас, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Ж.Сүхбаатар нар цахимаар тус тус үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12-т заасны дагуу санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.

Ж.Мөнхбат: Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай анхдагч хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	14
Татгалзсан:	2
Бүгд:	16
87.5 хувийн саналаар дэмжигдлээ.	

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2021.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ж.Батбаясгалан, Нийслэлийн Засаг даргын зөвлөх Р.Дагва, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Б.Мөнгөншагай, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш Д.Ганзориг, судлаач Д.Мөнх-Эрдэнэ нар “Жанжин Д.Сүхбаатар” танхимаас оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Бямбадулам, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, реферет Э.Баттогтох нар байлцав.

Төслийн эцсийн хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12-т заасны дагуу Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар ажлын хэсгийн гаргасан саналын томьёллоор санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.

Ж.Мөнхбат: Төслийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулж, дугаарлалтыг өөрчлөх:

“11.2.Энэ хуулийн 8.2-т заасан тусгай чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг улсын болон орон нутгийн төсвөөс, 8.3-т заасан бусад чиг үүргийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	13
Татгалзсан:	3
Бүгд:	16

81.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12-т заасны дагуу “Хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар ажлын хэсгийн гаргасан саналын томьёллоор санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.

Ж.Мөнхбат: Тогтоолын төслийн 1 дэх заалтаас “Нийслэл Улаанбаатар хотын дагуул” гэснийг, төслийн 2 дахь заалтыг бүхэлд нь тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	13
Татгалзсан:	3
Бүгд:	16

81.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /анхны хэлэлцүүлэг/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т “Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ.” гэж заасны дагуу Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж, хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

-Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 18 минутад хэлэлцэж дуусав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т “Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ.” гэж заасны дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

-Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлгээр нь баталъя гэсэн горимын санал гаргав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12-т заасны дагуу санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.

Ж.Мөнхбат: Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 6

Бүгд: 16

62.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 21 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Монгол Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Бямбадулам, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн референт Ч.Батбаяр, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

“Монгол Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Ж.Мөнхбат танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг, Ц.Мөнхцэцэг нар “Жанжин Д.Сүхбаатар” танхимаас үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12-т заасны дагуу санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.

Ж.Мөнхбат: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг намрын чуулганы хэлэлцэх асуудлын дараалалд оруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7
Бүгд: 16
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг намрын чуулганы хэлэлцэх асуудлын дараалалд оруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 9
Бүгд: 16
43.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Ж.Мөнхбат: “Монгол Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 6
Бүгд: 16
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 36 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Төрийн албаны зөвлөлийн 2019, 2020 оны үйл ажиллагааны тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Д.Зүмбэрэлхам, С.Цэдэндамба, Д.Баатарсайхан, Б.Идэрчулуун, Төрийн албаны зөвлөлийн Сонгон шалгаруулалтын газрын дарга Т.Сосорбарам, Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн удирдлага, аудитын газрын дарга Я.Хишигт, Төрийн албаны зөвлөлийн Сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн хэлтсийн дарга Л.Санжрагчаа, мөн газрын ахлах референт Л.Лхамжав, Төрийн албаны зөвлөлийн Стратегийн төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлага хариуцсан ахлах референт Ж.Жамъянтив нар “Жанжин Д.Сүхбаатар” танхимаас оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, реферет Э.Баттогтох, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн референт К.Пүрэвсүрэн нар байлцав.

Төрийн албаны зөвлөлийн 2019, 2020 оны үйл ажиллагааны тайланг Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг “Жанжин Д.Сүхбаатар” танхимаас танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг, Б.Пүрэвдорж нарын тавьсан асуултад Төрийн албаны зөвлөлийн гишүүн Д.Зүмбэрэлхам, С.Цэдэндамба, Б.Идэрчулуун нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын Ж.Мөнхбат, Ё.Баатарбилэг, Н.Энхболд нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Төрийн албаны зөвлөлийн 2019, 2020 оны үйл ажиллагааны тайланг сонсов.

Хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 32 минут үргэлжилж, 19 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 84.2 хувийн ирцтэйгээр 13 цаг 42 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Ж.МӨНХБАТ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2021 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
7 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР /ЛХАГВА ГАРАГ/-ИЙН
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ**

Ж.Мөнхбат: Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүдийнхээ өглөөний амгаланг айлтгая.

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүдээс А.Адъяасүрэн, С.Амарсайхан, Ё.Баатарбилэг, Д.Тогтохсүрэн, Ц.Мөнх-Оргил, Ц.Мөнхцэцэг, Х.Нямбаатар, Ж.Сүхбаатар нарын гишүүд цахимаар, С.Бямбацогт, Ж.Мөнхбат нарын гишүүд танхимаар хүрэлцэн ирж ирц бүрдсэн учир Төрийн байгуулалтын байнгын хорооны өнөөдрийн хуралдааныг эхлүүлж байна.

Төрийн байгуулалтын байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар 5 асуудлыг авч хэлэлцэнэ.

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Засгийн газар 2021 оны 6 сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн. Эцсийн хэлэлцүүлэг хийнэ.

Монгол Улсын Их Хурлын хяналт, шалгалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт нарын 15 гишүүн 2021 оны 7 сарын 02-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Төрийн албаны зөвлөлийн 2019-2020 оны үйл ажиллагааны тайлан гэсэн эдгээр асуудлуудыг авч хэлэлцэнэ.

Өнөөдрийн хуралдаанаар тавдугаар асуудлаар Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн тайлан авч хэлэлцэх байсан. Энэ асуудлыг намрын чуулганаар хойшлуулж байгаа. Тийм учраас дөрвөн асуудлыг авч хэлэлцэж хэлэлцэхээр шийдэж байна.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүн байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалд оръё.

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Цахим хуралдааны үеийн дэгээр явна. Эцсийн хувилбарын төсөл болон эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг гишүүдэд тараасан байгаа.

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг Та бүхэндээ уншиж танилцуулъя.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 6 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2021 оны 7 сарын 06-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Тус байнгын хороо 2021 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан явуулсан болно.

Нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас Монгол Улсын Их Хурлын чуулган, чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д заасны дагуу төслийн зарим нэг заалтыг гүйцээн боловсруулах чиглэл өгсний дагуу ажлын хэсэг хэсгээс зарчмын зөрүүтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан зарчмын зөрүүтэй саналуудыг төсөлд нэмж тусган, төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, Байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийслэл хотын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүд болон “Хот байгуулах тухай тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж, хуулийн төслийг эцэслэн баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Өчигдөр болсон Улсын Их Хурлын нэгдсэн чуулган дээр Улсын Их Хурлын дарга хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгсөн хоёр асуудал байгаа. Санал хураалт явуулах уу?

Нэг.Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол. Гүйцээн боловсруулах чиглэлтэй.

1.Төслийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг болгон нэмж доор дурссанаар өөрчлөн найруулж, дугаарлалтыг өөрчлөх:

“11.2.Энэ хуулийн 8.2-т заасан тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх шаардлагатай хөрөнгийг улсын болон орон нутгийн төсвөөс, 8.3-т заасан бусад чиг үүргийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.”

Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо гэж байна.

Санал хураалт явуулах нь. Гишүүд цахимаар санал хураалт авна. iPad-аа бэлдээрэй. Ажлын хэсгийг танилцуулъя. Энэ Хурлын дарга, Засаг дарга хоёр чинь ажлын хэсэг дээрээ ирдэггүй юм уу?

Одоо хууль нь батлагдаад дуусаж байгаа гээд ирэхгүй гэж байгаа юм уу? Тийм ээ. Тэгвэл хоёр даргыг чинь иртэл энэ асуудлыг хэлэлцэхээ түр больё.

Хоёр дарга руугаа ярь. Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдаж байгаа шүү. Ирэхгүй бол дараагийн асуудалдаа орлоо. Ажлын хэсгийг хүрэлцэн иртэл дараагийн асуудлыг хэлэлцэнэ.

***Нэг.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай
хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд
Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт нарын 15 гишүүн 2021.07.02-ны өдөр
өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/***

Хоёрдугаар асуудал. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Улсын Их Хурлын гишүүн Сандагийн Бямбацогт нарын 15 гишүүн 2021 оны 7 дугаар сарын 02-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх хэсгийг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчдын илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга Сандагийн Бямбацогт танилцуулна.

С.Бямбацогт: Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Парламент ёсны хувьд нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн тодорхой гурван чиг үүрэг байдаг. Манай гишүүд нэлээн сайн мэднэ.

Хууль тогтоох, иргэд, сонгогчдыг төлөөлөх, хянан шалгах гэсэн чиг үүргүүд байдаг.

Манай улсын хувьд ч онолын энэхүү зарчмыг Үндсэн хуульдаа тусгасан.

Өнгөрсөн 30 жилийн хугацаанд Улсын Их Хурлын хууль тогтоох, төлөөлөх бүрэн эрх тодорхой түвшинд хэлбэржин тогтсон. Харин хянан шалгах, бүрэн эрхээ хэрэгжүүлэх тал дээр үр нөлөө багатай хэрэгжүүлж ирсэн ийм байгаа.

Ийм учраас 2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр эрх мэдлийн хяналт, тэнцлийг хангах зорилгоор Улсын Их Хурлын хянан шалгах бүрэн эрхийг шинэ шатанд гаргах зарчмын өөрчлөлтийг Үндсэн хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсгээр хийсэн.

Энэ хүрээнд Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Ё.Баатарбилэг, Ж.Ганбаатар, С.Ганбаатар, Ц.Даваасүрэн, Г.Дамдинням, Л.Мөнхбаатар, Ж.Мөнхбат, Ц.Мөнх-Оргил, Ц.Мөнхцэцэг, Н.Наранбаатар, С.Одонтуяа,

Б.Пүрэвдорж, Г.Тэмүүлэн, Б.Энхбаяр нарын 15 гишүүн Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн анхдагч хуулийн төслийг боловсруулж 2021 оны 7 сарын 02-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүллээ.

Энэ хуулийн төслийн үзэл баримтлалын хувьд юуны өмнө Улсын Их Хурлын Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд “Хууль тогтоомжид нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 02 дугаар тогтоолд заасан үзэл баримтлалын хүрээнд боловсруулах шаардлага үүссэн.

Түүнчлэн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийн нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөлөл, тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор гарч байгаа хүндрэл бэрхшээл, цаашид тухайн хууль тогтоомжийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлох болон тэдгээрийг хэрэгжүүлэхээр Засгийн газраас батлан гаргасан хэм хэмжээний актууд хуульд хэрхэн нийцэж байгаа эсэхэд нэгдсэн хяналт тавих тогтолцоо хангалтгүй байгаа нь Улсын Их Хурлын хяналт шалгалтыг шинэ шатанд гаргах шаардлага гарч байгаа юм.

Иймд хуулийн төслийг 7 бүлэг, 69 зүйл бүхий анхдагч хуулийн төслийг боловсруулсан.

Хуулийн төслөөс онцлох зохицуулалтуудыг Та бүхэндээ танилцуулъя.

Нэгдүгээрт нь, Улсын Их Хурлын хяналт шалгалтын зорилго, түүнийг хэрэгжүүлэх зарчим болон асуулт тавих, асуулга тавих, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, Их Хурлаар тайлан, мэдээлэл, илтгэл сонсох, хэлэлцэх, төсвийн хяналт, хяналтын сонсгол хийх, хянан шалгах буюу мөрдөн шалгах Түр хороо байгуулах зэрэг Улсын Их Хурлын хяналт шалгалтын долоон төрлийн арга хэрэгслийг нарийвчлан хуульчилж, хяналт шалгалтын үр дүнд хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, эрчимжүүлэх, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, холбогдох албан тушаалтанд хариуцлага хүлээлгэдэг байх эрх зүйн орчныг бүрдүүлэхийг нэгдүгээрт нь зорилго болгосон.

Хоёрдугаарт нь, Байнгын хороо болон дэд хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналт, мөн холбогдох хуулиудаар зохицуулсан Улсын Их Хуралд тайлагнах, хууль тогтоомжийн биелэлтийн тайлан, илтгэл, мэдээллийг уялдуулан нэгтгэж, Улсын Их Хурлын хяналт шалгалтын үр нөлөөг сайжруулах зорилгоор нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн, шаардлагатай гэж үзвэл Улсын Их Хурлын тогтоол гаргахаар тусгасан байгаа.

Гуравдугаар нэг зарчмын асуудал бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн явцад хуримтлагдсан өгөгдлүүдийг задлан шинжилж, гарч байгаа хүндрэл бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид хууль тогтоомжийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбар, хууль тогтоомжийг боловсронгуй болгох хүрээг тодорхойлох зорилгоор хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг тогтмол хийх, мөн үүнийгээ нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж байхаар тусгасан.

Мөн холбогдох Байнгын хороо шаардлагатай гэж үзсэн бол хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын баталсан дүрэм, журам тухайн хуульд нийцэж байгаа эсэхэд үнэлгээ хийхээр төсөлд тусгасан.

Дөрөвдүгээр нэг зарчмын асуудал бол хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгслийг тайлагнах зарчмыг шинэ шатанд гаргаж байгаа.

Тухайлах юм бол одоогийн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг жил жилд Байнгын хороод хэлэлцээд нэг сонсоод өнгөрдөг байдлыг өөрчилж, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний тухайн жилд төлөвлөсөн арга хэмжээ нь хэдэн хувийн хэрэгжилттэй, чанарын ямар шалгуурыг хэрхэн хангаж байгааг төсөл, арга хэмжээ тус бүрээр хувиар нь хэлэлцэх.

Энэ нь дөрвөн жилийн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд заасан зорилтын хэдэн хувьд хүрч байгаа нэгтгэн Байнгын хороо, Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар хэлэлцдэг байх.

Ийнхүү хэлэлцээд Улсын Их Хурал улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг хэлэлцээд, шаардлагатай гэж үзэх юм дараа жилийн улсын хөгжлийн төлөвлөгөөний төсөл боловсруулах болон холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох асуудлаар Засгийн газарт тогтоолоор чиглэл өгөхөөр тусгасан.

Урт, дунд хугацааны хөгжлийн баримт бичгийн хэрэгжилтийг мөн энэ зарчмаар Улсын Их Хурал хянан хэлэлцдэг. Төлөвлөлт, тайлагналт хоёрыг хамтад нь ярьдаг байхаар зохицуулалт оруулж байгаа.

Тавдугаарт нь, төсвийн хяналтын хувьд төсвийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үе шатны. Мөн хэлэлцүүлгийн болон хэрэгжилтэд хяналт тавих хяналтын хэлбэрүүдийг тусгаж, хяналтын аль ч шатанд шаардлагатай гэж үзэх юм бол төсвийн хяналтын сонсголыг зохион байгуулахаар тусгаж, Улсын Их Хурлын Тамгын газрын төсвийн хяналт шинжилгээний нэгж, Улсын Их Хурал төсвийн хяналтаа хэрэгжүүлэхэд шаардлагатай хараат бус бодит мэдээлэл, судалгаагаар хангаж ажиллахаар тусгасан.

Зургаадугаарт нэг зарчмын томоохон өөрчлөлт оруулж байгаа.

Хяналтын сонсголын хувьд нэгдүгээрт нь хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсгол.

Хоёрдугаарт нь, төсвийн хяналтын сонсгол.

Гуравдугаарт нь, ерөнхий хяналтын сонсгол.

Дөрөвдүгээрт нь, нэр дэвшигчийн буюу томилгооны сонсгол гэсэн дөрвөн төрөлтэй байхаар төсөлд тусгасан.

Онцлох зохицуулалт нь эдгээр хяналтын сонсголыг Улсын Их Хурлын 5-аас доошгүй гишүүн, эсхүл Байнгын, дэд хороо, Түр хорооны нийт гишүүдийн олонх, эсхүл цөөнхийн бүлэг хүсэлт гаргаснаар эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөгдөж байгаа иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг тухайн асуудал эрхэлсэн Байнгын болон дэд, Түр хороо хэлэлцэн хүлээн авснаар эдгээр сонсголыг зохион байгуулж явуулахаар ийм уян хатан зохицуулалтыг хийж өгч байгаа.

Долоод нь, нэр дэвшигчийн сонсгол буюу томилгооны сонсгол нь олон талын тэнцвэртэй оролцоо, баримт, судалгаанд үндэслэн нэр дэвшигчийн тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангасан эсэх, зохих мэдлэг чадвар, туршлага мэргэжилтэй эсэхийг олон нийтэд танилцуулах, нэр дэвшигч хараат бусаар

ажиллах, ёс зүйн шаардлага хангасан эсэхийг нээлттэй ил тодоор хэлэлцэх, нэр дэвшигчийн хүлээн зөвшөөрөгдөх байдлыг хангах зорилготой нэр дэвшигчийн сонсгол нь Улсын Их Хурлаар зөвшилцөх, томилогдох, танилцах албан тушаалтнуудыг бүгдийг нь нэр дэвшигчийн сонсгол, томилгооны сонсгол, танилцах гэсэн гурван хэлбэртэй байхаар тусгаж өгч байгаа.

Нэр дэвшигчийн сонсголыг эрхлэх асуудлын хүрээнд холбогдох Байнгын хороо зохион байгуулах бөгөөд нэр дэвшигчийн сонсголыг нэр дэвшигчийг санал болгох, нэр дэвшигчийг судлах, сонсголыг товлон зарлах, сонсголд оролцогч болон бусад этгээдийг бүртгэх, мэдэгдэх, сонсголыг явуулах, сонсголын тайлан гаргах гэсэн үе шаттай байхаар төсөлд тусгасан.

Наймдугаар нэг зарчмын асуудал олон улсын парламентын зүгээс гүйцэтгэх эрх мэдэлд хяналт тавих олон хэлбэрүүд байдгаас хамгийн хүчтэй, үр нөлөөтэй хяналтын хэлбэр болох мөрдөн шалгах чиг бүрхий хянан шалгах хорооны зохицуулалтын төслийг 6 дугаар бүлэгт тусгасан.

2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн гүйцэтгэх эрх мэдлийг бэхжүүлсний зэрэгцээ, түүнд тавих хяналтыг сайжруулах заалтууд оруулсны нэг нь Үндсэн хуулийн 28.2-т хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах Түр хороо байгуулах санал тавибал Улсын Их Хурлын цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна.

Байнгын болон бусад хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно гэж Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт заасан.

Улсын Их Хурлын 19-өөс доошгүй гишүүн санаачилбал Хянан шалгах Түр хороог заавал байгуулж, түүний бүрэлдэхүүнийг тогтоох болон хянан шалгах бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд нь цөөнхийн бодит оролцоог хангах, сонсголоор, үнэн бодитой мэдээллийг ил тод хэлэлцэх замаар гүйцэтгэх эрх мэдэл буюу Засгийн газар, түүний харьяа байгууллагуудад тавих парламентын хяналтыг илүү үр нөлөөтэй болгох, гүйцэтгэх эрх мэдлийн хариуцлага, ил тод, нээлттэй байдлыг дээшлүүлэх, нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар бодит мэдээлэл олж авах, иргэний мэдэх эрхийг хангах нь энэ зохицуулалтын гол үзэл баримтлал юм.

Түр хорооны бүрэлдэхүүнийг тогтоохдоо Улсын Их Хурал дахь олонх, цөөнхийн төлөөллийг хувь тэнцүүлэн оролцуулах, Улсын Их Хурал дахь нам, эвсэл бүрийн төлөөллийг оролцуулах зарчмыг баримтална.

Хянан шалгах Түр хороонд орох гишүүнээ нам, эвслийн бүлэг өөрөө томилж, өөрөө чөлөөлөх эрхтэй. Хянан шалгах Түр хороо нь шинжээч томилох, гэрчээр дуудан ирүүлэх, гэрч, шинжээчээс мэдүүлэг авах, нотлох баримт гаргуулах, газар дээр нь очиж шалгалт хийх, бичиг баримтын дүн шинжлгээ хийх зэрэг хянан шалгах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Үүгээрээ хяналтын төсөөтэй арга хэлбэрээс илүү эрх мэдэлтэй байгаагаараа онцлог. Бүтэн бүлэг болгон зохицуулсан байгаа.

Хянан шалгах Түр хороо нь нийтийн сонсгол хийх замаар гэрч, шинжээчид дуудаж мэдүүлэг, тайлбар сонсох, баримт мэдээллийг цуглуулж авахаар шийдвэрлэх бөгөөд Ерөнхий сайд, сайдыг асууж хариулт авч болно.

Түр хорооны гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь ямар гэрчээс мэдүүлэг авах, хэнийг шинжээчээр томилох, ямар баримт авах, Хянан шалгах Түр хорооны үйл ажиллагаанд саад учруулсан зөрчилд хариуцлага тооцох эсэхтэй холбоотой тодорхой эрхийг эдлэхээр хуулийн төсөл тусгасан байгаа.

Хяналт шалгалтын Түр хорооны ажлын үр дүнд дүгнэлт, зөвлөмжийг багтаасан тайлан гаргаж, хэвлэн нийтлэх бөгөөд Улсын Их Хуралд танилцуулж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхээр тус тусгасан.

Эцэст нь хэлэхэд Үндсэн хуулийн эх баригч Б.Чимид гуайн хэлснээр “Эцсийн дүнд сайн хууль гаргаж, түүнийхээ биелэлтийг хянан шалгаж, бодитой үр дүнд хүрэх явдал хууль тогтоох үйл ажиллагааны үндсэн агуулга.” гэж хэлсэн байдаг.

Хураангуйлж хэлэх юм “хууль тогтоох үйл ажиллагаа” бол хууль гаргах буюу хуулийг хэлэлцэн батлах, баталсан хуулийнхаа биелэлтийг хянан шалгах хоёрын нийлбэр гэж хэлсэн байдаг. Үүнийг хууль тогтоогч бид бүхэн анхаарч, байнгын ажилдаа зарчим болгож ажиллах ёстой.

Энэ үүднээсээ Улсын Их Хурлын хяналт шалгалтын анхдагч хуулийг батлах. Энэ хууль батлагдсанаар Улсын Их Хурлын хууль тогтоох, төлөөлөх, хянан шалгах бүрэн эрх шинэ шатанд гаргах боломж бүрдэнэ гэж үзэж байгааг хууль санаачлагч бид үзэж Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороонд хэлэлцэх эсэхийг нь шийдэж өгнө үү хэмээн хэлэлцүүлэхээр оруулж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Та бүхнийг хэлэлцэх эсэхийг шийдэж, дэмжиж өгнө үү гэж Та бүгдээс хүсэж байна.

Ж.Мөнхбат: Улсын Их Хурлын гишүүн, хууль санаачлагчдын ахлагч С.Бямбацогтод баярлалаа.

Энэ маш чухал хууль байгаа юм. Энэ хуулийг өнөөдөр Төрийн байгуулалтын байнгын хороогоор хэлэлцэж байна. Өнгөрсөн жил бид Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийсэн.

Тэгээд энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль орж ирж байна.

Тэгээд бид парламентын засаглалтай улс.

Сүүлийн үед нийгэмд нэг зүйл яригдаж байгаа. Нэг намын дарангуйлал ч гэдэг юм уу, нэг хүний дарангуйлал энэ тэр гээд ингэж яригдаад байгаа шүү дээ. Сошиалаар.

Тэгэхээр тийм юм бол байхгүй. Цаашдаа парламентын засаглалыг төгөлдөржүүлэх, сонгодог парламентын засаглал руу төлөөллийн ардчиллыг улам төлөвшүүлэхэд чиглэсэн хамгийн том алхам хийж байгаа ийм чухал хууль гэдгийг хэлье.

Ингээд хууль санаачлагчдын илтгэл, төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна.

Үг хэлэх гишүүн байна уу? М.Оюунчимэг гишүүн. Тасаллаа.

Асуулт уу? Д.Тогтохсүрэн гишүүн ээ, Ж.Сүхбаатар гишүүн ээ. Үг үү?. Асуулт байна. Д.Тогтохсүрэн гишүүн асууя.

Д.Тогтохсүрэн: Хуулийн төслийг дэмжиж байна. Гарах ёстой хууль.

Энэ Улсын Их Хурлаас гаргасан 02 дугаар тогтоол байгаа юм. Би хуулийн боловсруулалттай танилцаад гурав, дөрвөн зүйлийг тодруулж асууя гэж бодож байгаа юм.

Нэгдүгээрт, энэ хуулийн хамгийн түрүүнд Түр хороо байгуулах асуудал байгаа юм.

Би зүгээр тэгж бодоод байгаа юм. Энэ Түр хороо бол маш чухал чиг үүрэгтэй Түр хороо байгаа юм.

Ж.Мөнхбат: Д.Тогтохсүрэн гишүүн ээ. Дуу чинь царгиад ерөөсөө сонсогдохгүй байна. Жаахан чангалах уу?

Д.Тогтохсүрэн: Чангалаад л байна. Би байдаг дээр нь тавиад байна. Одоо сонсогдож байна уу?

Ж.Мөнхбат: Ер нь л бүдэг байна.

Д.Тогтохсүрэн: Одоо сонсогдож байна уу?

Ж.Мөнхбат: Д.Тогтохсүрэн гишүүнд минутыг нь эхнээс нь өгье. Та чанга яриарай.

Д.Тогтохсүрэн: Энэ Хянан шалгах Түр хороо үнэхээр чухал ач холбогдолтой. Энэ хуулийн амин сүнс гэж ингэж үзэж байгаа юм.

Энэ Түр хороо бол маш чухал чиг үүрэгтэй. Нотлох баримт цуглуулна. Дүн шинжилгээ хийнэ. Тодорхой шаардлагатай гэвэл гэрчүүдээс мэдүүлэг авна. Томилно гээд чухал чиг үүрэгтэй юм.

Бид энэ бүрэлдэхүүнийх нь байдлыг харахаар цөөнхийн эрх давамгайл харагдаад байгаа юм. Нийт 19 гишүүнийх нь гуравны нэг нь буюу 7 гишүүн нь цөөнхөөс байна. Цөөнх нотлох баримт цуглуулна. Цөөнх шинжилгээ, судалгаа хийнэ гээд.

Цөөнхийн эрх хамаагүй давуу харагдаад байна. Парламент дахь суудлын харьцаа ойрхон байх юм бол энэ ийм сайн зүйл биш байгаа юм. Яагаад заавал энэ цөөнхийг хэт их оруулж ирэв гэдэг. Цаашдаа олонх ч үйл ажиллагаагаа явуулахад хүндрэл учрах тийм байдлыг үүсгэж магадгүй гэж би тэгж бодоод байгаа байхгүй юу. Үүнийг нэгдүгээрт тодруулж асууя гэж бодож байна.

Хоёрдугаарт нь, томилгооны сонсгол, зөвшилцөх сонсгол, танилцах сонсгол гээд дотроо олон сонсголүүд байгаа юм. Үүнийг заримыг нь Байнгын хороон дээр

явуулдаг, заримыг нь бид яваандаа болох болов уу гэж би бодоод байна. Жишээлбэл, Эрүүл мэндийн даатгалын зөвлөлийн, Нийгмийн даатгалын зөвлөлийн даргын.

Нэг баахан олон сонсгол болчихсон байгаа байхгүй юу. Сонсгол би хэт их олон болсон юм болов уу гэж бодоод байгаа юм. Хууль санаачлагч үүнийг юу гэж үзээд байгаа юм.

Гуравдугаарт, 17, 18 дугаар зүйл маш олон тайлангууд бид үзэхээр байна. Засгийн газрын.

Тэгэхээр мэргэжлийн сайд нь 5 жилийн тайлан гээд тайлангаа тавих. Үйл ажиллагааны тайланг. Бид хугацааны хувьд 4 сарын 01-ний дотор буюу 2 сарын 01-ний дотор аудитын байгууллагад өгнө гэдэг.

Засгийн газрын сайдын тайлан чинь 3 сарын 15-ны дотор ордог байхгүй юу. Тэгэхээр цаг хугацааны хувьд жаахан зөрөөд байгаа юм харагдаад байгаа юм. Тэрийг жаахан уялдуулах хэрэгтэй байвал яасан юм бэ гэж бодож байгаа юм.

16 дугаар зүйл тэр тайлантай холбоотой асуудал байгаа юм.

Ж.Мөнхбат: Хууль санаачлагч Сандагийн Бямбацогт гишүүн хариулъя.

С.Бямбацогт: Д.Тогтохсүрэн гишүүний асуултад хариулъя.

Тэр Улсын Их Хурлын хянан шалгах Түр хороонд цөөнхийн төлөөлөл яагаад их олон байгаа юм бэ гэсэн асуулт асууж байна.

Цөөнхийн төлөөлөл гуравны нэгээс доошгүй байна гэж оруулсан байгаа. Тийм. Доошгүйн цөөнхийн төлөөлөл. Өөрөөр хэлэх юм бол 19-өөс доошгүй гишүүн санаачилж хянан шалгах Түр хороо байгуулж болно. Түүнийх нь гурав нэгээс доошгүй нь цөөнхийн төлөөлөл байна.

Өөрөөр хэлэх юм парламентын хяналт гэдэг цөөнхийн хяналтыг тодорхой хэмжээнд оролцуулах үйл явц юм. Тийм үүднээс оруулж ирсэн.

Үндсэн хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт бид оруулчихсан шүү дээ. Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах Түр хороо байгуулах санал тавивал цөөнхийн төлөөллийг оролцуулан Улсын Их Хурлын тогтоолоор уг хороог заавал байгуулна гээд Үндсэн хуульд заачихсан байгаа юм.

Өөрөөр хэлэх юм бол Үндсэн хуулийнхаа үзэл баримтлалд нийцүүлж цөөнхийн төлөөллийг оролцуулсан. Оролцуулахдаа гуравны нэгээс доошгүй нь. Гэхдээ тэр парламентад суудалтай намуудын жигд төлөөллийг хангах ийм зорилгоор хянан шалгах буюу мөрдөн шалгах Түр хороог байгуулахаар орж ирж байгаа.

Өөрөөр хэлэх юм парламент бол хууль тогтоохоос гадна хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ бид хамгийн гол нь цөөнхийн хяналтаас тодорхой оролцоотой байх гэдэг үүднээс оруулж өгсөн.

Энэ дээр манай О.Мөнхсайхан багш нэмээд хариулчихаарай.

Хоёр дахь асуултын тухайд томилгооны сонсгол зайлшгүй хийгдэх ёстой юу гэж асуудал яригдаж байна. Томилгооны сонсгол Улсын Их Хурлаар томилогддог, Улсын Их Хуралтай зөвшилцдөг, Улсын Их Хурлаар танилцуулдаг энэ албан тушаалтангуудаар хийдэг нь зайлшгүй байх ёстой юм.

Ер нь хэдхэн хүмүүсийн хүрээнд, хэдэн дарга нарын хүрээнд хүмүүс оруулж ирээд гэнэтхэн томилоод явчихдаг. Энд Улсын Их Хурлын гишүүдээс авхуулаад, олон нийт дургүйцдэг. Болох болохгүй янз янзын гэмт хэрэг, янз янзын зөрчил, асуудалд холбогдож байсан ийм хүмүүс томиллоо гэж. Үүнээсээ болоод Улсын Их Хурлын нэр хүнд унадаг.

Тийм болохоор Улсын Их Хурлаар орж ирж байгаа томилогдох, сонгогдох, танилцах албан тушаалтныг заавал томилгооны сонсгол хийж байж олон нийт ийм хүн томилно.../минут дуусав/

Ж.Мөнхбат: С.Бямбацогт гишүүн 1 минут нэмж өгье.

С.Бямбацогт: Тэгж томилгооны сонсгол хийж байж нэгдүгээрт нь тэр үнэхээр шалгуур, шаардлага хангасан хүн мөн үү, биш үү гэдгийг олон нийтийн оролцоотойгоор.

Нөгөө талдаа нөгөө томилогдох гэж байгаа хүн нь бас үнэхээр хүлээн зөвшөөрөгдөх. Үнэхээр сайн хүн томилогджээ. Энэ ажлаа сайн хийж чадах байх гэдэг нь нөхцөлийг нь хүлээн зөвшөөрөгдөх үүднээс бид томилгооны сонсгол заавал хийдэг байх ёстой. Оруулж байгаа.

Дараагийн асуудал бол тэр олон тайлан илтгэл, мэдээлэл хэлэлцэх гээд байна гэж. Урьд нь хэлэлцдэг байсан илтгэл, тайлан, мэдээллүүдийг цөөлсөн байгаа. Зайлшгүй хэлэлцэх ёстой. Одоо юу гэдэг юм. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, жилийн төлөвлөгөөний биелэлт, төсвийн гүйцэтгэл. Эдгээрийг цаг хугацааны хувьд уялдуулж оруулж ирсэн. Үүнийг бас манай Ц.Болормаа зөвлөх нэмээд хариулчихаарай. Энэ зайлшгүй уялдах ёстой.

Бид энэ дээр Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль болон Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль дээр манай Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтнууд нэлээн суусан.

Цагалбарын хувьд хооронд нь уялдуулах ажлыг нэлээн сайн зохицуулж хийсэн байгаа. Энэ тал дээр манай Ц.Болормаа зөвлөх нэмээд хариулчих.

Ж.Мөнхбат: Ж.Сүхбаатар гишүүн асуулт асууна.

Ж.Сүхбаатар: Би энэ дээр асуултаасаа илүүтэй үг байгаа юм.

Энэ хуулийн төслийн боловсруулах ажлын хэсэгт миний бие оролцсон байгаа. Тэгээд яагаад хууль санаачлагчаар оролцоогүй юм бэ гэхээр энэ Их Хурлаас Байнгын хорооноос байгуулагдах ажлын хэсэгт нь орж ажиллая гэж бодоод ингээд санаачлагчаар оролцоогүй.

Тэгээд өнөөдөр бол үйл явдал тохиолдож байгаа юм. Түрүүн Байнгын хороон дарга их зөв хөндөж байна. Бид 30 жилийн дараа парламент маань ард түмнийг төлөөлөх, хууль тогтоох гэсэн энэ үүргийнхээ. Тэр “сонгодог парламентын ардчилал” гээд л яриад байгаа. Бид сонгодог нь зарим нь байдаг, байдаггүй л гээд байгаа юм.

“Сонгодог” гэдэг маань ер нь Европ маягийн. Бүр нарийн ярих юм “Вестминстер” гээд яриад байгаа Британи маягийн загвар шүү дээ. Парламент хууль ноёрхдог. Ялангуяа парламент ноёрхох ийм засгийг хэлж байгаа юм. Ер нь бол.

Гэхдээ яах вэ, бид бас нэг Герман маягийн тогтолцоо, хуулиа либерал ардчиллын хүрээнд авсан ийм юмнууд бий.

Тэгээд энэ хүрээндээ хамгийн гол юм бол бид ард түмнийг төлөөлөх энэ чиг үүргээ энэ сая Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр нэлээн тодотгосон. Ард түмнийг төлөөлөөд зүгээр нэг хууль баталдаг байгууллага мэтээр явцуурдаг. Зарим нь тайлбарладаг байсан.

Тэгэхээр энэ бол ард түмнийг төлөөлдөг, ард түмний засаглах үүргийг хангадаг байгууллага юм.

Тийм учраас ард түмнийг төлөөлнө, хууль тогтооно. Мөн хянан шалгана. Хууль тогтоомжийн биелэлт. Одоо бид парламентын 30 жилийн дараа дараах үе шатанд орж ирж байна.

С.Бямбацогт гишүүнийг би онцолж баяр хүргэх гэж байгаа юм. Сүүлийн 10 жилийн хугацаанд өмнөх 2008-2012 оны парламентаас авхуулаад Их Хурлын гишүүдийн ажлын албыг бэхжүүлэх, парламентын зохион байгуулалтын үйл ажиллагааг сайжруулах тал дээр ерөөсөө тууштай сүүлийн 10 жил ажилласан.

Одоо үүний хамгийн оргил юм нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээн дэх парламентын төгөлдөршил дээр бид сая 2019 онд 2019-2024 оны Улсын Их Хурлын стратеги төлөвлөгөөг баталсан. Тэр дотор энэ парламентын хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлэх асуудал ч тусгагдчихсан байгаа. Заалтуудаараа.

Тэгэхээр энэ удаа орж ирж байгаа нь манай парламент гэдэг бол төлөөлнө, хууль тогтооно.../минут дуусав/

Ж.Мөнхбат: Ж.Сүхбаатар гишүүнд 1 минут нэмж тодруулъя.

Ж.Сүхбаатар: Хуулийн биелэлтийг бид хангана. Энэ парламентын хяналтыг хүчтэй болгоно. Энэ парламент гэдэг чинь Ерөнхийлөгчийн зарлигийг хүчингүй болгодог. Засгийн газрын шийдвэрийг хүчингүй болгодог. Засгийн газрын холбогдох албан тушаалтан, байгууллагуудын үйл ажиллагааг хянан шалгадаг. Зорилго нь хуулийг нэг мөр энэ улс оронд биелүүлэхийг шаарддаг ийм тогтолцоо юм.

Тэгэхээр өнөөдөр парламент бол шүдгүй арслан шиг байсан бол энэ шүдээ ургуулаад ингээд ажиллах ёстой. Энэ бол айгаад байх зүйл биш.

Монголын ардчиллын дархлаа. Түрүүний хэлдгээр парламент ёс Монгол улсад ноёрхож байх тэр гол нөхцөлийг бүрдүүлэх юм бол одоо энэ хууль байгаа юм.

Энэ хуулийг хурдан хугацаанд олон талаас нь хэлэлцээд гаргах явдал 2022 оноос эхлээд Монгол Улсын Их Хурал жинхэнэ 30 жилийн дараа бусад

парламентад байгаагүй хэмжээнд өөрийн хянан шалгах бүрэн эрхээ эдлэх ийм эрх зүйн орчинтой болох юм. Үүнийг ил тод шууд хэлэх хэрэгтэй.

Манай Улсын Их Хурал дахь Ардын намын бүлэг маш том шинэтгэлийн бодлогуудыг хэрэгжүүлж байгаагийн нэг юм нь энэ том бодлогын арга хэмжээ.../минут дуусав/

Ж.Мөнхбат: Ж.Сүхбаатар гишүүн үг хэллээ.

Түрүүн Д.Тогтохсүрэн гишүүний асуулт дээр ажлын хэсэг Ц.Болормаа гишүүн нэмээд хариулчих. Тодотгоод. 6 номерын микрофон.

Ц.Болормаа: Сайн байна уу. Тамгын газрын ажилтан Ц.Болормаа байна. Д.Тогтохсүрэн гишүүний асуултад хариулъя.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дэгийн тухай хуулиар Улсын Их Хуралд тайлагнадаг, тайлан, сонсгол, илтгэл, мэдээлэл нийт 19 байсныг энэ хуулийн төсөл дээр 14 болгож оруулж ирж байгаа.

Ингэхдээ холбогдох байгууллагуудын саналыг нь аваад давхардуулалгүйгээр 14 болгож цөөлсөн байгаа. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгүүдийн цагалбар зөрж байна гэж байна. Үүнийг зөрүүлээгүй.

Нэгдүгээрт, Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн цагалбаруудтай уялдуулж нийцүүлээд Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийнхаа 14, 15, 17, 18 дугаар зүйлүүдэд холбогдох өөрчлөлтийг оруулаад цагалбаруудыг нийцүүлсэн байгаа.

Ингэхдээ олон тайлан төлөвлөгөөг хэлэлцэх биш, жилийн хөгжлийн төлөвлөгөөг дөрвөн жил, таван жилийнхээ баримт бичигтэй уялдуулаад нэг хавтгай дээр нэгтгэж хооронд нь тайланг нь хэлэлцдэг байх тийм зарчмын өөрчлөлт орсон байгаа.

Ж.Мөнхбат: Доктор О.Мөнхсайхан хариулах уу? Ажлын хэсэг. Номер 1 микрофон.

О.Мөнхсайхан: Баярлалаа. Тэгэхээр төгс Д.Тогтохсүрэн гишүүний эхний асуулт дээр хянан шалгах Түр хороог Их Хурлын нийт гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь санаачилж цөөнхийн төлөөллийг оролцуулна гэдэг ийм заалт Үндсэн хуулийн 28.2-т орсон.

Энэ цөөнхийн төлөөлөл гуравны нэгээс доошгүй байгаа боловч олонх бол энэ Түр хороонд олонх хэвээрээ байж байгаа. Яг пропорцоороо хувь тэнцүүлж орж байгаа юм.

Тэгэхээр Түр хороо дийлэнх шийдвэрээ олонхоороо гаргадгаараа ингээд гаргаад явна. Гэхдээ бас Үндсэн хуулийн дөрөвний нэгээс доошгүй тооны Их Хурлын гишүүд санаачилж байгуулж байгаа учраас Түр хороо дотроо тодорхой асуудал дээр дөрөвний нэгээс доошгүйн саналаар нотлох баримт цуглуулах зэрэг тэр зарчмууд яг олон улсын жишигт энэ хороо яаж ажилладаг түүгээрээ тусаж орсон байгаа.

Энэ нэр дэвшигчийн сонсгол өөрөө маш чухал. Дөнгөж өчигдөр Хууль зүйн байнгын хороо анх удаа томилгооны сонсголыг яг Байнгын хорооныхоо хувьд хийсэн. Энэ туршлага дээр үндэслэсэн олон улсын жишгүүдийг харгалзсан байдлаар нэр дэвшигчийн сонсголыг Их Хурлаас зөвшилцдөг, томилдог, танилцдаг.

Хараат бусаар бие дааж ажиллах үүрэг бүхий албан тушаалтанд нэр дэвшиж байгаа тэр хүмүүс дээр сонсгол хийх зохицуулалт орж ирсэн. Энэ нь Их Хурлын гишүүд тухайн нэр дэвшигчийн шаардлага хангаж байгаа, хангаагүй талаарх тал талын мэдээллийг бүрэн бодитой сонсож, илүү мэдээлэлтэй тийм шийдвэр гаргахад нь туслах зорилготой. Нөгөө талаараа олон нийтэд тухайн нэр дэвшигч мэдлэг чадвар, ёс зүйгээрээ тухайн албыг нэр төртэй хашна гэдэг тэр шаардлагыг нь хангаж байгаа эсэхийг нь таниулах. Улмаар тэр нэр дэвшигчийн дараа нь тэр ажлаа хийхэд нь хүлээн зөвшөөрөх тэр байдлыг нь.../минут дуусав/

Ж.Мөнхбат: Та бүхэн доктор О.Мөнхсайхан, ажлын хэсгийн зөвлөх Ц.Болормаа, С.Бямбацогт гишүүн нарын хариултаас энэ хууль, мөн Ж.Сүхбаатар гишүүний хэлсэн үг байна.

Ямар чухал хууль болохыг энд хэллээ.

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Ё.Баатарбилэг, Ж.Ганбаатар, С.Ганбаатар, Ц.Даваасүрэн, Г.Дамдинням, Л.Мөнхбаатар, Ж.Мөнхбат, Ц.Мөнхцэцэг, Н.Наранбаатар, С.Одонтуяа, Б.Пүрэвдорж Г.Тэмүүлэн, Б.Энхбаяр нарын 15 гишүүн хуулийн төслийг өргөн барьсан байгаа.

Ер нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан бид энэ парламентат засаглалаа төгөлдөржүүлэх алхмуудыг хийж байгаа. Тэгээд үүний хамгийн чухал нэг алхам бол өнөөдрийн С.Бямбацогт нарын 15 гишүүний өргөн барьсан, санаачилсан энэ хууль байж байгаа юм.

Ингээд Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо М.Оюунчимэг гишүүн үг хэлнэ. Түрүүн үг хэлэх гишүүдийг нэрс авчихсан байгаа. М.Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Улсын Их Хурлын хяналт шалгалтын энэ анхдагч хуулийг бид оройтож хэлэлцэж байна гэж би харж байгаа.

Өмнөх дөрвөн жил Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үед ард иргэдээс авсан санал асуулгаар хүмүүсийн жар, далан хувь нь шударга бус байдлыг дургүйцэж байгаа. Энэ Монголд шударга ёс тогтож хүн биш хууль засагладаг байх нь чухал байна гээд.

Тэгээд ялангуяа Улсын Их Хурал маш чухал хуулийг батлаад л гаргаад байдаг. Гүйцэтгэх засаглалын түвшинд, дунд, доод шатанд энэ хууль хэрэгждэггүй нь өөрөө төрд итгэх итгэлийг бүр алдруулж байна гэдгийг өнөөдөр хүн бүхэн ярьж байгаа.

Өчигдөр Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга тэргүүтэй гишүүд Төрийн албаны зөвлөл дээр ажилласан. Тэнд бүр Төрийн албаны зөвлөлийнхөн өөрсдөө ч өнөөдөр ярьж байна л даа. Энэ төрийн алба өөрөө яг үнэнийг хэлэхэд сүүлийн энэ арав, хорин жил галзуугийн эмнэлэг шиг болчихоод байна. Нэг хэсэг нь яг даргын хүрээний хүмүүс нь цаас барьж гүйдэг нь илүү үнэлэмжид ордог. Нэг

хэсэг нь чимээгүй ажлаа гүйцэтгэж явдаг. Гэхдээ үр дүн байдаггүй. Нөгөө ур чадвар, хариуцлага, ёс зүй гэдэг алдагдаад байна.

Тийм учраас Улсын Их Хурлын хяналт шалгалтын авдагч энэ хуулийг яаралтай батлан гаргавал бидэнд ч энэ ажлаа гүйцэтгэхэд хэрэгтэй байна гээд ярьж байсан.

Би бас нэг жишээ хэлье. Өчигдөр бид эмч нарын эрүүл мэндийн үйлдвэрчний эвлэлийн төлөөлөгч нартай уулзлаа. Тэдний гол зорилго цалин хөлсөө шууд хоёр дахин нэмүүлэх гэдэг нь бидний зорилго биш.

Харин даргын шударга бус томилгоо, шударга бус хөрөнгө, санхүүгийн хуваарилалт, шударга бус хандлага бидний бухимдлыг төрүүлж байна.

Тиймээс Их Хурал энэ эрх зүйн орчин, эдийн засгийн орчныг бүрдүүлсэн чинь тэр төсөв захиран зарцуулагч дээр, тэр эмнэлгийн дарга нарын хүрээнд, Эрүүл мэндийн яамны хүрээнд, Эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн хүрээнд энэ чинь шийдэгдэхгүй байгаа нь биднийг бухимдуулаад байна. Үүнийгээ Та нар шударга ёсоор шийдээд өгөөч ээ гээд байгаа юм.

Тэгэхээр бид энэ хууль гарсны дараа Улсын Их Хурал, Улсын Их Хурлын харьяа Байнгын хороод эндээс гаргасан хууль тогтоомж дээр хөрөнгө мөнгөний хуваарилалт эзэндээ очиж байна уу, шударга хуваарилалт тэнд байна уу, үгүй юу гэдгийг шалгах эрх нь нээгдэх юм.

Тийм учраас энэ хуулийг бид маш яаралтай хэлэлцэж батлах ёстой гэж бодож байгаа. Дэмжиж байгаа учраас энэ дэмжих эсэхийг нь хэлэлцсэний дараа эхний хэлэлцүүлгээр нь энэ хуулийг батлаад хаврын чуулган үүнийг гаргах хэрэгтэй гэж харж байна.

Тэгж байж бид өнөөдөр энэ ард иргэдийнхээ итгэлийг авна. Төрийн нэр хүнд сайжирна. Дээрээс нь шударга бус юм алга болно.

Түрүүн С.Бямбацогт даргын хэлээд байгаа үнэн л дээ. Одоо хэдхэн дарга нарын хүрээнд томилгоо, хуваарилалт явагдаад байдаг. Тэгээд тэр нь яг очих эзэндээ очихгүй. Хуваарилах газраа хуваарилагдахгүйгээс болоод нийгэмд эмх замбараагүй байдал үүсэх үндэс шалтгаан ч болох магадлалтай болоод байна.

Гэтэл бид хэдэн зуун тэрбумаар нь санхүүжилтийг төсөв захиран зарцуулагч нарт шаардлагатай гээд л гаргаж өгөөд байдаг. Сая аудитын дүгнэлтээр энэ КОВИД-ын үеийн эдийн засгийн болоод, нөгөө тусламжууд яг тодорхой тусгагдахгүй байна гээд дүгнэлт гараад ирсэн.

Одоо энэ Байнгын хороодод ирүүлж байгаа тайлан хэдэн сараар хоцорч ирж байна гээд. Бид өмнөх дөрвөн жил бас тэгээд л шүүмжлээд байсан. Энэ нь өөрөө жаахан тийм назгайрах, хавтгайрах, гүйцэтгэх засаглалын түвшинд, ялангуяа хурган дарга нар, дунд дарга нар, агентлаг.../минут дуусав/

Ж.Мөнхбат: М.Оюунчимэг гишүүнд 1 минут нэмж өгье.

М.Оюунчимэг: Бүх шатанд ингээд нэг назгайрсан, ингээд эргээд хяналт байдаггүй. Тэгж байгаад л болдог юм гээд. Эсвэл ганц нэг сайд нь ч юм уу, өөр хүмүүст нь хариуцлага тооцоод яг тэр бугшсан идээ бээрийг нь бид арилгаж чадахгүйгээс болоод төрийн алба үнэхээр сул болоод байна.

Гэтэл Монгол төр иргэддээ үйлчлэх ёстой. Гүйцэтгэх засаглал шударга ажиллах ёстой байдаг. Энэ нь дэндүү нааз гараад байгаа учраас, энэ хууль үнэхээр чухал ач холбогдолтой байгаа учраас миний бие энэ үг хэлэхдээ эхний хэлэлцүүлгээр нь үүнийг батлах саналыг хэлэлцэх эсэхийг хийсний дараа хийгээд саналыг маань дэмжээд өгөөч ээ гэсэн санал гаргаж байна. Баярлалаа.

Ж.Мөнхбат: Цахимаар Ж.Сүхбаатар гишүүн үг хэлнэ.

Ж.Сүхбаатар: Би тэгэхээр түрүүн Д.Тогтохсүрэн гишүүн энэ сонсгол чинь их олон байна гээд ингээд жаахан шүүмжлэлтэй хандаж байх шиг байна лээ.

Би бол даргын тэр байр суурийг жаахан өөрөөр харах гээд байгаа юм. Одоо чинь юм нарийсаж байна шүү дээ. Д.Тогтохсүрэн гишүүн ээ.

Одоо энэ сонсгол чинь манайд дандаа томилгооны сонсгол явагдах бололцоогүй. Зөвшилцдөг, танилцдаг, тэгээд томилдог нэг ийм гурван хэлбэр байгаа шүү дээ. Үүнийгээ дагаад сонсголоо ингээд нарийсгах нь зөв.

Одоо ер нь парламент аль болгон ер нь юмыг ерөнхий тавих вэ. Цаашдаа дэг ч гэсэн ер нь их нарийн болох байх. Улам л нарийсаад байгаа. Амьдрал өөрөө хөгжиж байгаа учраас ер нь нарийсах шаардлагатай болж байна шүү дээ. Би тэр утгаараа энэ сонсголыг нарийвчилж задалсныг нь зөв гэж бодож байгаа.

Тэгээд дээр нь хэлэхэд энэ хяналт шалгалтын юманд эмзэглээд байх хэрэггүй байгаа юм. Ер нь парламентаас ард түмэн олон зүйлийг шаардаж байгаа.

Сая М.Оюунчимэг гишүүн ч хэлж байна. Тэгээд үүний шаардлагын чинь ихэнх нь сайн хууль батлаад өг гэхээс илүүтэй гаргасан хуулиа нэг олигтойхон шиг мөрдүүлээдэхээч ээ. Дарга дагасан хүмүүст нэг өөр үйлчилдэг. Дарга дагаагүй хүмүүст нэг өөр үйлчилдэг. Даргатай ойр хүмүүст нэг өөр үйлчилдэг. Ийм байдлуудаа болиоч л гээд байгаа шүү дээ.

Тэгэхээр парламент өөрөө яг ард түмний индэр учраас хяналт шалгалтын үйл ажиллагаа нь ил тод үндсэндээ явагддаг. Тэгээд ард түмний өмнө тайлагнадаг, ард түмнийхээ хяналтад байдаг, сонгогддог, хариуцлага тооцох боломж нь илүү байдаг.

Тэгэхээр ийм тохиолдолд бид парламент өөрөө өөртөө хязгаарлалт бий болгож байгаа.

Ер нь юм гэдэг чинь бас нэг талдаа хүчтэй байх гол үндэс нь олон түмний итгэлийг бэхжүүлэх чиглэлд байгаа шүү дээ. Энэ парламентын хяналт шалгалтыг хүчтэй болгох гээд байгаагийн цаад санаа нь парламент ард түмний холбоосыг бэхжүүлж, ард түмний итгэх итгэлийг нэмэгдүүлэх, тавигдах шаардлагыг нь өндөржүүлэх ийм л асуудал байгаа. Хаа хаанаа.

Тэгээд энэ утгаараа Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг түрүүн оройтож орж ирлээ гэж. Үнэн л дээ. 30 жилийнхээ юмыг бид нэгтгээд дүгнээд л одоо ингээд Үндсэн хуулийн том бодлогынхоо хүрээнд оруулж ирж байгаа юм.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар дарга ч гэсэн энэ сүүлийн хоёр жилийн хугацаанд маш том бодлого явуулж байгаа юм. Хоёр удаа өөрөө

дараалаад сонгогдож байна. Би бол энэ улсуудыг нэр зааж хэлж байгаа юм. Энэ Г.Занданшатар дарга, энэ С.Бямбацогт, энэ О.Мөнхсайхан нарын гэдэг юм уу. Эрдэмтэн судлаачид, манай Байнгын хорооны.

Сүүлийн хоёр жил шал өөр сэтгэлгээ, арга барил, хандлагатай болж ирж байгаа шүү дээ. Бодож байгаа, сэтгэж байгаа, хийж байгаа үйлдлүүд нь, ярьж байгаа зүйлүүд нь бодит ажил хэрэг болж өнөөдөр ч гэсэн томилгооны сонсголууд бид хийгээд л явж байна.

Тэгэхээр ам ажил ингээд зэрэгцээд явж байх бодит боломж энэ Хяналт шалгалтын хуулиар бүрдэж байгаа юм. Ийм Их Хуралд ажиллаж энэ ажлыг хийхэд оролцож байгаадаа би хувьдаа баяртай байгаа. Үүнийгээ энд дурдаад. Энэ протокол ч гэсэн дараа дараачийн хүмүүс анх Улсын Их Хурлын хяналт шалгалтын хууль хэлэлцэж байх үед Ж.Сүхбаатар гишүүн ингэж хэлж байсан гэж бас дурсан санаж бодоосой.

Монгол Улсын парламент бол төрт ёсоо бэхжүүлэх, хөлд орж яваа, Монголын төрийг бэхжүүлэх ийм алхмууд л явж байгаа шүү дээ. Бидний зовлон жаргал бол байгаа дүр төрх маань ийм л хэмжээнд явж ирсэн. Одоо бид.../минут дуусав/

Ж.Мөнхбат: Ж.Сүхбаатар гишүүн их чухал үг хэллээ.

Одоо танхимаас Ц.Мөнхцэцэг гишүүн үг хэлнэ.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр парламентын хяналт шалгалт энэ ардчилсан засаглалын хүчтэй байх, хяналттай байх, эрх мэдэл тэнцвэртэй байх үйл ажиллагааг хангах гол механизм байдаг.

Өнгөрсөн 30 жилийн хугацаанд Улсын Их Хурлын үйл ажиллагаа гүйцэтгэх засаглалд тавих хяналт тааруу байсан гэдэг шүүмж маш их байдаг.

Тийм учраас 2020 оны Улсын Их Хурлын сонгуулиар бүрдсэн шинэ парламент маань Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг даган гарч байгаа маш чухал хууль болох энэ парламентын хяналт шалгалтын хуулийг санаачлаад бидний арван хэдэн гишүүн энэ санаачлах дээр орж ажилласан.

Тэгэхээр парламентын хяналт ерөөсөө улс орнуудын гүйцэтгэх засаглалдаа тавьж байгаа парламентын гол хяналтын чиг үүрэг хэрэгжүүлдэг. Энэ дотор онцгойлон төсвийн хяналт. Мөн парламентаас батлагдсан хууль тогтоомжуудын хяналтыг парламент хийх ёстой.

Тэгээд энэ хуулийн төслийг санаачлан бичих явцдаа манай Улсын Их Хурлын Тамгын газар, Улсын Их Хурлын Судалгааны хүрээлэн Америкийн Нэгдсэн Улс, мөн Холбооны Бүгд Герман Улсын парламентуудын хяналт шалгалтын үйл ажиллагаатай танилцаж, тодорхой мэдээлэл, судалгааны ажлууд солилцож нэлээд олон улсын жишээг харсан.

Ер нь энэ парламентын хяналтын чиг үүрэг бол Монгол Улсын өнгөрсөн 30 жилийн түүхэнд өнөөгийн энэ хуулиар орж ирж байгаа шиг ийм хүчтэй, хатуу зохицуулалт байгаагүй юм. Энэ хуулийн төсөлд парламентын хянан шалгах Түр хороо бол яг Герман Улсын Бундестагийн хянан шалгах Түр хороотой адил дүйхүйц хэмжээний ийм хянан шалгах, нотлох баримт цуглуулах, гэрчийн мэдүүлэг авах зэрэг онцгой эрх мэдлүүдийг олгосон байгаа.

Тэгэхээр Улсын Их Хурлын зүгээс энэ төсвийн хяналтыг хэрэгжүүлэх. Тэр дотор гүйцэтгэх засаглалын тодорхой том хөтөлбөрүүд, өндөр мөнгөн дүн бүхий төсвийн томоохон бодлогуудад хяналт тавих энэ үүрэг асар чухал байдаг.

Тэгээд хяналт шалгалтын бас нэг дараагийн гол үүрэг бол энэ иргэдээс ирж байгаа мэдээлэлд үндэслэн хүний эрхийн болон тодорхой зөрчлүүдийн мөрөөр хяналт хийх, мөн иргэдийн дунд тодорхой хэмжээний асуудал, хардлага байгаа тохиолдолд тэр асуудлаар нийтийг хамарсан томоохон асуудлаар бид хяналт шалгат хийх бүрэн боломжтой болж байгаа юм.

Тэгээд энэ Улсын Их Хурлын хяналт шалгалтын хуулийг боловсруулах, хуулийн төслийг боловсруулахад хамтран ажилласан манай Их Хурлын гишүүд болон манай Улсын Их Хурлын Судалгааны хүрээлэн, мөн манай дэд ажлын хэсэгт байгаа гишүүд, эрдэмтэн судлаачдаас чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Үндсэн хуульт ёсны дагуу парламентын засаглалын дагуу төрийн бүх засаглалууд харилцан тэнцвэртэй, хяналттай байх ёстой. Энэ жил бид өнөөдөр ингээд томоохон алхам бүхий хууль баталж байна. Баярлалаа.

Ж.Мөнхбат: Цахимаар Д.Тогтохсүрэн гишүүн үг хэлнэ.

Д.Тогтохсүрэн: Би хуулийн төслийг дэмжиж байгаа юм.

Сонсогдож байна уу? Ж.Мөнхбат дарга аа.

Ж.Мөнхбат: Ер нь их сул сонсогдож байна шүү.

Д.Тогтохсүрэн: Миний iPad ингээд байгаа юм.

Тэгэхээр би хуулийн төслийг дэмжиж байгаа юм. Гэхдээ хуулийн төслийн дараагийн хэлэлцүүлэг дээр анхаараарай гэж санал хэлэх гээд. Тэгээд зарим нь эсэргүүцээд байгаа юм шиг юм яриад яваад байх юм.

Нэгдүгээрт, би томилгооны сонсгол ярих ёстой гэдэгтэй санал нэг байгаа юм. Хэт олон болчихоод байгаа юм. Чуулганд орон тооны бүх хүмүүсийг томилгооны сонсгол гэж хэрэггүй байхгүй юу. Тэр Үндэсний олон нийтийн телевиз байна. 15 гишүүнтэй. Тэр 15 орон тооны бус гишүүний томилгооны сонсгол хийх гэж. Яах гэж тэгж цаг авч. Тэр Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл гээд 7-гоос 8 гишүүн, зарим нь 9 гишүүнтэй. Дандаа орон тооны бус.

Орон тооны бусуудыг бол бид хэлэлцэж хэрэггүй байхгүй юу. Томилгооны сонсгол. Тухайлбал, зөвшилцөх санал. Зөвшилцөх саналыг бид заавал томилгооны сонсгол гэж хэрэггүй шүү дээ. Тэр Улсын дээд шүүхээс 24 шүүгчээр томилгооны сонсгол хэрэггүй шүү дээ. Танилцах сонсгол гэдгээр.

Зөвшилцөх гэдгээр бас одоо Элчин сайд нарыг бүгдийг томилгооны сонсгол болох юм уу. Тэгэхээр зөвшилцөх, танилцах сонсголыг заавал хэрэг байна уу, үгүй юу. Дараагийн юманд оруулъя. Хэлэлцэх ёстой байх гэж бодож байгаа юм.

Хянан шалгах Түр хороон дээр уг нь харьцаагаараа байгаа байхгүй юу. Харьцаагаараа болохоороо наадах чинь яваандаа маш урхагтай шүү дээ. Тухайлбал 36-гийн харьцаатай байх юм бол 19-өөр байнгын сонсгол, байнгын

хяналт шалгалтын Түр хороотой болчихож байгаа байхгүй юу. 19-өөр. Та нар тоогоо сайн бодож үзээрэй.

Нэг талаасаа парламентын хяналт сайн байгаа боловч нөгөө талаасаа олонхийн засаглалд сөрөг нөлөөлөл гарах вий гэдэг талаас нь би хараад байгаа юм.

Тэр тайлантай холбоотой асуудлаар мөн ялгаагүй 13 тайлан авч үзнэ гэж. 13 тайлан дотор чинь зарим нь Байнгын хороогоор явах байгаа байхгүй юу. Жишээлбэл, статистикийн тайланг бол Байнгын хороогоороо явах ёстой байхгүй юу. Заавал чуулган руу оруулаад. Дагаж тогтоол гаргаад ингээд, өөрөөр хэлбэл энд их хэмжээний цаг зарим юм байна гэж.

Тэр 17, 18 дугаар зүйл дээр Засгийн газрын тайлантай холбоотой, төлөвлөгөөтэй холбоотой юм нь дээр өмнөх оны улсын төсвийн гүйцэтгэл чинь өөрөө 3 сарын 01-нээс өмнө гардаггүй байхгүй. Тэгээд төсвийн гүйцэтгэл гараагүй. Төсөвтэй холбоотой юмнуудын эцсийн үр дүн гараагүй байхад бид төлөвлөгөөний биелэлт хэлэлцэхээр чинь энэ чинь формаль болох гээд байгаа байхгүй юу. Миний санаа бол жаахан хойшлуулвал яасан бэ гэдэг ийм санаа байгаа байхгүй юу. Хоёрдугаар улиралд нь хэлэлцэх юм бол бүх юм баталгаатай байна байхгүй юу.

Ийм хэдэн саналууд байна. Тэгээд дараагийн хэлэлцүүлэг дээр үүнийг авч үзэх байх гэж ингэж бодож байна. Баярлалаа.

Ж.Мөнхбат: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураана.

Манай гишүүд бүртгэлийн санал хураалт явуулъя. Бүртгэлийн санал хураалт.

Одоо хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Б.Пүрэвдорж гишүүн дэмжиж санал өгсөн. Техникийн саатал гарсан байна.

16 гишүүн санал хураалтад орж, 14 гишүүн дэмжиж санал дэмжигдлээ.

Санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг уншина.

Дараагийн асуудалдаа оръё.

Эхний асуудлаар ажлын хэсэг хүрэлцэн ирсэн бол үргэлжлүүлъя.

Хоёр. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2021.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийнэ.

Ажлын хэсгийг оруулаарай. Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль дээр. Өчигдөр нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийг Улсын Их Хурлын чуулганаар нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын даргаас гүйцээн боловсруулах чиглэл өгсөн.

Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд энэ асуудлаар ажлын хэсэгтэй санал нэгдсэн үү? Нямаагийн Энхболд гишүүний микрофоныг өгье.

Н.Энхболд: Их Хурлын даргын чиглэл өгсөн асуудлаар ярьсан.

Энэ орон нутгийн зэрэглэлтэй хот, дагуул хот энэ тэртэй холбоотой зүйлүүд. Ялангуяа Улаанбаатар хотыг тойрон байрладаг Төв аймагтай холбоотой асуудал байсан учраас бид зарчмын зөрүүтэй саналууд ярьж байсан.

Тэгээд чиглэл өгсний дагуу хотын удирдлагатай уулзсан. Д.Сумъяабазар даргатай, Хурлын даргатай уулзсан. Энэ Р.Дагва зөвлөх ирчихсэн байж байна. Хуулийн зөвлөх нь байна.

Ерөнхий сайдтай бас уулзсан. Их Хурлын даргатай ярьсан. Тэгээд бид ерөнхийдөө нэг ойлголтод хүрсэн. Тэгээд түүнийхээ дагуу Байнгын хороонд ийм байдлаар шийдэж болох юм байна гээд саналаа өгсөн. Томьёоллоо ирүүлчихсэн байна лээ. Тэр саналаар хураагаад явчхаад асуудлын нэг хэсэг нь шийдэгдчих байх гэж бодож байна.

Ж.Мөнхбат: Тэгвэл санал гаргасан гишүүн ажлын хэсэг санал нэгдсэн юм байна гэж ойлголоо. Санал хураалт явна. Гүйцээн боловсруулах чиглэлтэй.

1.Төслийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг болгон доор дурссанаар өөрчлөн найруулж, дугаарлалтыг өөрчлөх:

“11.2.Энэ хуулийн 8.2-т заасан тусгай чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг улсын болон орон нутгийн төсвөөс, 8.3-т заасан бусад чиг үүргийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.”

Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал хураалт. Дэмжье гэдэг саналын томьёоллоор. Дэмжинэ шүү.

Санал хураалтад 16 гишүүн оролцсоноос 13 нь дэмжиж, 81.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дараагийн санал.

Хоёр. ““Хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй санал.

Улсын Их Хурлын даргаас, хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгсөн байгаа.

Тогтоолын төслийн 1 дэх заалтаас “Нийслэл Улаанбаатар хотын дагуул” гэснийг, төслийн 2 дахь заалтыг бүхэлд нь тус тус хасах.

Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Санал хураалт.

Энэ дээр ойлголцсон гэж ойлгож байгаа шүү дээ. Ажлын хэсэг. Тийм үү? Санал хураалт.

16-гаас 13 гишүүн дэмжиж, 81.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Цахимаар Болдын Жавхлан гишүүн санал гаргаж байгаа юм байна.

Зарчмын зөрүүтэй санал. Үг хэлье гээд байна.

Б.Жавхлан: Ж.Мөнхбат гишүүн ээ. Баярлалаа.

Байнгын хороон дарга аа. Юу шүү. Энэ нөгөө нэг яг энэ заалттай холбоотой биш байгаа юм. Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолол дээр санал хэлэх гэсэн юм. Тэр нь арай болоогүй байгаа юм шиг байна.

Ж.Мөнхбат: Хэдийн ямар заалт вэ? Одоо ингээд дуусаж байна шүү.

Б.Жавхлан: Ингэж байгаа. Засгийн газраас өргөн мэдүүлсэн төсөл дээрээ 8.4, энэ хуулийн 8.2-т заасан тусгай чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ гээд Засгийн газраас өргөн барьсан нэг ийм заалт, хувилбар байгаа юм.

Энэ дээр ажлын хэсэг маань арай өөр саналтай томьёолол оруулаад ирсэн байгаа. Тэгээд тэр дээр би саналаа хэлэх гэсэн юм.

Товчхондоо Засгийн газраас оруулж ирсэн энэ анхны хувилбарыг нь дэмжиж өгөөч ээ. Энэ дээр арай өөр өнцгөөр нэг ажил хэрэгч байдлаар харж өгөөч ээ гэж ажлын хэсэгт санал хүсэлт тавих гэсэн юм. Та хэд маань үүнийг нэг хэлчхэж өгөөч ээ.

Ж.Мөнхбат: Б.Жавхлан сайд аа. Ийм байна.

Анхны оруулж ирсэн 8.4-т энэ хуулийн 8.2-т заасан тусгай чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ гэсэн ийм төсөл орж ирсэн.

Тэгээд дөнгөж сая хоёр санал хураалт явуулсны эхний санал хураалт нь тэр 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулж дугаарлалтыг өөрчлөх гээд. 11.2 гээд энэ хуулийн 8.2-т заасан тусгай чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг улсын болон орон нутгийн төсвөөс, 8.3-Т заасан бусад чиг үүргийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ гэдэг санал гараад ингээд дэмжигдчихсэн байгаа шүү дээ.

Б.Жавхлан: Өө тийм үү?

Ж.Мөнхбат: Б.Жавхлан гишүүнд 1 минут өгье.

Б.Жавхлан: Тэгвэл их баярлалаа. Тэгвэл ингээд болчихож байгаа юм байна шүү дээ.

Би түрүүнд тэгвэл дутуу буруу ойлгосон байна.

Ж.Мөнхбат: Энэ Улсын Их Хурал, Төрийн байгуулалтын байнгын хороо бол Засгийн газрын өмнөөс ингээд ажлыг нь хийгээд байгаа юм гэдгийг Сангийн сайдад хэлье. Баярлалаа танд.

Б.Жавхлан: Баярлалаа.

Ж.Мөнхбат: Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Нийслэлийн Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль дээр манай Засгийн газрын хэд хэдэн гишүүд санал санаачилга гаргаж, төслийн зарчмын зөрүүтэй санал гаргаж санал хураалгая гэсэн ийм саналууд ирүүлсэн. Гэхдээ хоёр гурван сайд. Гэхдээ ингээд Төрийн байгуулалтын байнгын хороо, ажлын хэсэг саналаа гаргаад саналаа хураагаад ингээд явж байгаа.

Тийм учраас сайд нарын ажлыг, Засгийн газрын ажлыг Төрийн байгуулалтын байнгын хороо хийж гүйцэтгээд яваад байгаа шүү гэдгийг дашрамд дурдъя.

Байнгын хорооны танилцуулгын чуулганынэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг танилцуулна.

Энэ хуультай холбогдуулан Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Нэмэлт мэдээлэл байна. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явах үед ажлын хэсгээс боловсруулсан зарчмын зөрүүтэй саналын томъёоллууд дэмжигдсэнтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасныг баримтлан Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулсан.

Дэгийн тухай хуулийн 39.10-т Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ. 39.11-д гишүүн хуулийн төслийн тухайн зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас болон бусад оролцогчоос асуулт асууж болно.

Цар тахлын үеийн дэгээр явж байгаа. Одоо ингээд хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ.

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр саналтай гишүүн байна уу? Цахимаар байна уу? Алга байна.

Тус хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг танилцуулна.

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Дараагийн асуудалд орно.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Одоо хуулийн төслүүдийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

2 дугаар зүйл дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

М.Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Энэ өөрөө нөгөө Нийслэлийн эрх зүйн байдлын хуулийнхаа эцсийн хэлэлцүүлэгтэй уялдаж байна.

Дээрээс нь бид үүнийг угаасаа тодорхой гишүүд асуулт асуух зүйл байхгүй байгаа.

Тэгэхээр анхны хэлэлцүүлгээр нь батлах саналыг гаргаж байгаа учраас үүнийг хэлэлцэж дэмжиж өгнө үү гэж хэлмээр байна. Баярлалаа.

Ж.Мөнхбат: М.Оюунчимэг гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулна.

Анхны хэлэлцүүлгээр нь баталъя гэсэн горимын санал гаргаж байгаа юм байна. Санал хураалт гишүүд ээ. Дэмжье гэсэн саналын томьёоллоор. Дэмжинэ шүү. Дагах нь хамт явж байгаа.

16 гишүүн оролцож, 10 гишүүн дэмжиж, 62.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

М.Оюунчимэг гишүүн уншихаар болсон. Тийм ээ.

Ингээд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооны гишүүд ажлын хэсэгт баярлалаа.

Дараагийн асуудалд оръё.

Гурав. “Монгол Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

“Монгол Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье.

Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Төрийн байгуулалтын байнгын хороо, нам, эвслийн бүлэг, Байнгын, дэд, Түр хороо, хууль санаачлагчийн саналыг үндэслэн дараагийн ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын дарааллын талаарх Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл, цаашид тогтоолын төсөл боловсруулан нэгдсэн хуралдаанд оруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар батална гэж заасны дагуу Төрийн байгуулалтын байнгын хороо “Монгол Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс 20, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс 18, Монгол Улсын Засгийн газраас 136, нийт 11 Байнгын хорооноос 62, Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд 8, Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут 1 хууль, тогтоолын төсөл, нийт 245 хууль, тогтоолын төслийг тогтоолын төсөлд тусгуулах саналаа албан бичгээр ирүүлсэн болно.

“Монгол Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулахдаа дараах зарчмыг баримталсан болно. Үүнд,

1. Намрын ээлжит чуулганаар хэлэлцэн батлахаар хуульд тусгайлан заасан хууль, тогтоомжийн төслүүд.

2. “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тоот тогтоолын хавсралтад заасан Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн өөрчлөх, шинэчлэх шаардлагатай хуулийн төслүүд.

3. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх зүйн орчин бүрдүүлэх чиглэлээр тэргүүн ээлжинд хэлэлцэх хууль, тогтоолын төслүүдийг тусгах зарчмыг баримтлан нийт 78 төслийг тогтоолын төсөлд тусгалаа.

Харин хэлэлцүүлгийн шатанд байгаа хууль, тогтоолын төслийг үргэлжлүүлэн хэлэлцэхээр тогтоолын төслийн хоёр дахь заалтад тусгасан юм байна.

Түүнчлэн КОВИД-19 цар тахлын үеийн нөхцөл байдалтай холбоотойгоор Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төсөл болон хууль санаачлах эрх бүхий субъектүүдээс өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг тухайн ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын дараалалд оруулахыг хуульд заасны дагуу Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлийн саналаар шийдвэрлэхээр тогтоолын төслийн гурав дахь заалтаар зохицуулсан болно.

Төрийн байгуулалтын байнгын хороо.

Улсын Их Хурлын тогтоолын төсөл болон танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна.

Үг хэлэх гишүүн байна уу? Ц.Мөнхцэцэг гишүүнээр тасаллаа. Ё.Баатарбилэг гишүүн.

Ё.Баатарбилэг: Тогтоолын төслийг дэмжиж байна.

Энэ дээр яах вэ нөгөө хэлэлцүүлгийн шатанд явж байгаа гэхээр энэ боловсролын багц хууль сая ороод ирсэн. Тийм ээ. Энэ бол явчихна гэж ойлгож байгаа. Боловсролын багц хууль.

Энэ дээр нөгөө Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг нэр зааж оруулаадхаач гэдэг хүсэлт, санал байгаа юм. Яагаад гэхээр энэ хэлэлцүүлгийн шат руу ороогүй. Тэгээд намрын чуулганы жагсаалтад оруулахгүй бол жагсаалтад ороогүй гэдгээр бас хэлэлцэхэд юу болчих болов уу гэсэн. Миний өргөн барьсан хууль байж байгаа юм. Тэгэхээр үүнийг.

Ер нь Төрийн албаны хуультай холбоотой хэд хэдэн юунууд Засгийн газраас ч гэсэн орж ирэх сураг байсан. Тэгэхээр үүнийг нэмээд оруулъя гэсэн санал байна.

Тэгэхээр зарчмын зөрүүтэй санал гаргах уу, яах ёстой вэ?

Ж.Мөнхбат: Ё.Баатарбилэг гишүүн ээ.

Ийм байгаа. Энэ нөгөө гурав дээр байгаа. Хэлэлцүүлгийн шатанд байгаа болон Монгол Улсын Ерөнхийлөгч, Их Хурлын гишүүд, Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн энэ тогтоолын нэгд зааснаас бусад хууль гээд ингээд орчхож байгаа.

Тэгэхээр хэлэлцүүлгийн шатанд байгаа буюу өргөн барьсан хууль орсон гэсэн үг. Тийм.

Ц.Мөнхцэцэг гишүүн.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг даган гаргах гол хуулиудын нэг нь Улс төрийн намын тухай хууль байгаа.

Улс төрийн намын тухай хууль бол бас манай энэ ардчиллын үзүүлэлтүүд, тэр дотроо нөгөө авлигын үзүүлэлтүүдийг бууруулахад нөлөөлөх ийм гол хууль. Тийм учраас Улсын Их Хурал бол энэ намрын чуулган болоод 2022 оны хаврын

чуулганыхаа аль нэгэнд энэ Улс төрийн намын тухай хуулиа батлах ёстой гэж үзэж байна.

Тийм учраас энэ дээр бас манай Байнгын хорооны дарга юу гэж бодож байна. Улс төрийн намын тухай хуулийн төслөө хэзээ оруулахаар ийм төлөвлөгөөтэй байгаа вэ?

Ж.Мөнхбат: Улс төрийн намын тухай хууль бол Улсын Их Хуралд өргөн баригдаагүй байгаа хууль.

Өнөөдөр Улс төрийн намын хуулийг боловсруулах ажлын хэсэг ажиллаад байж байгаа.

Тэгэхээр өргөн баригдаагүй байгаа учраас өргөн баригдах юм бол намрын чуулганаар даргын дэргэдэх зөвлөл дээр яриад ингээд энэ хэлэлцэх асуудлын дараалалд ороод явах бүрэн боломжтой. Ийм байгаа шүү гэдгийг хэлье.

Ингээд Байнгын хорооны гишүүд үг хэлж дууслаа.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж санал гаргаж байгаа юм байна.

2021 оны намрын ээлжит чуулганд хэлэлцэх асуудлын тухай тогтоолд Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж.

Өргөн барьсан хууль бол Б.Пүрэвдорж гишүүн ээ. Энэ гуравдугаар зүйл дээр байгаа шүү дээ. Хэлэлцэх асуудлын дараалалд орчихсон байгаа гэсэн үг.

Б.Пүрэвдорж гишүүн үг хэлье.

Б.Пүрэвдорж: Нэмэгдсэн өртгийн албан татварын хувь хэмжээ өнөөдрийн байдлаар 10 хувь байгаа.

Энэ 10 хувь бол ялангуяа алслагдмал бүс нутагт амьдарч байгаа ард иргэд, дээрээс нь жижиг, дунд бизнес эрхэлж байгаа, мөн түүнчлэн үйлчилгээний салбарын хувийн хэвшилд маш тийм дарамт үүсгэдэг.

Тийм учраас өнөөдрийн байдлаар нийт хувийн аж ахуйн нэгжийн 30 орчим хувь нь л нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлдэг. Хэрвээ 5 хувь болох юм энэ нэмэгдсэн өртгийн албан татварын төлөгч аж ахуйн нэгжүүд маш олноор бүртгүүлэх. Ингэснээр татварын бааз суурь нэмэгдэх боломж үүсэж, улсын төсөвт оруулж байгаа орлого нь буурахгүй улам өсөх ийм тооцоолол гарсан.

Тийм учраас энэ Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх асуудлын жагсаалтад нэрээр нь оруулж өгөхийг хүсэж байна.

Тэгэхээр энэ гуравдугаар жагсаалт дээр ингээд ороод явдаг. Харамсалтай нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг энэ хаврын чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад орсон боловч хэлэлцээгүй.

Тийм учраас нэрээр нь заавал оруулж, санал хураалгаж өгөхийг Их Хурлын гишүүн зарчмын зөрүүтэй санал гаргасан бол үүнийг заавал хэлэлцэх.

Ж.Мөнхбат: Б.Пүрэвдорж гишүүн заавал нэрээр нь оруулна гэж байгаа юм байна. Тийм үү?

Б.Пүрэвдорж гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя.

2021 оны намрын ээлжит чуулган хэлэлцэх асуудлын тухай тогтоолд Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг оруулъя гэсэн санал гаргаж байгаа юм байна.

Өнөөдрийн манай хэлэлцэж байгаа энэ тогтоолын 3 дугаар зүйлээр энэ өргөн баригдсан хуулийн төслүүд орж байгаа. Гэхдээ тухайн гишүүн заавал нэрээр нь оруулъя гэдэг санал гаргаж байгаа учраас санал хураалт явуулъя. Санал хураалт.

Б.Пүрэвдорж гишүүн Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр тэтгэмж олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Энэ дараалалд байгаа даа.

Б.Пүрэвдорж гишүүний гаргасан саналаар санал хураалт явуулъя. Б.Пүрэвдорж.

Б.Пүрэвдорж: Тэгэхлээр энэ Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж олгох тухай хуулийн төсөл, агуулгыг нь би Та бүхэнд хэлж өгье.

Тэгэхээр 2016 онд эдийн засгийн нөхцөл байдал хүндэрсэнтэй холбоотойгоор Олон Улсын Валютын Сангийн хөтөлбөрийг манай улсад хэрэгжүүлсэн. Энэ Олон Улсын Валютын Сангийн зөвлөмжийн дагуу Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж олгохдоо урьд нь таван жилийн дундаж цалингаас тэтгэврийг тогтоодог байсан долоон жилийн цалингийн дунджаас тооцож тэтгэвэр тогтоодог болсон. Үүний улмаас дунджаар 100 мянга орчим төгрөгийн тэтгэврийг бага тогтоолгоод байгаа.

Тэгэхлээр өнөөдөр Олон Улсын Валютын Сангийн хөтөлбөрөөс манай Монгол Улс гараад хэдэн жил болж байна.

Тийм учраас эдийн засгийн нөхцөл байдал илүү сайн түвшинд хүрнэ. Энэ тохиолдолд бид бүхэн энэ шударгаар нийгмийн даатгалаа төлсөн тэр иргэдэд энэ тэтгэврийг нь зохих ёсоор өгөх ажлыг хийх ёстой.

Тийм учраас тэтгэвэр тогтоох хувь хэмжээг долоон жилээс тооцдог байсныг таван жил болгох тухай хуулийн төсөл өргөн баригдсан байгаа. Хаврын хэлэлцэх асуудлын дараалалд энэ хууль орсон боловч харамсалтай нь бас дахиад хэлцэлгүй хасагдсан.

Тийм учраас яг нэрээр нь оруулж өгөхийг хүсэж байна. Энэ 28 дээр байгаа Нийгмийн даатгалын сангаас олгох Тэтгэврийн тухай хуулийн хуулийн төсөл чинь шинэчилсэн найруулга байхгүй. Минийх өөрчлөлт. Тийм учраас энэ асуудлаар санал хураалт явуулж өгөөч ээ гэж Байнгын хорооны даргаас хүсэж байна. Баярлалаа.

Ж.Мөнхбат: Б.Пүрэвдорж гишүүний гаргасан саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг намрын чуулганы хэлэлцэх асуудлын дараалалд оруулъя гэсэн ийм санал гаргажээ. Санал хураалт.

16 гишүүнээс 7 гишүүн дэмжиж санал дэмжигдсэнгүй.

Би санал өгсөн ч найм наймаар дэмжигдэхгүй юм байна. Эхнийхийг чинь дэмжсэн шүү.

“Монгол Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт гишүүд ээ. Дэмжье гэдэг томьёоллоор.

16-гаас 10 гишүүн дэмжиж, 62.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны санал дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг танилцуулна.

“Монгол Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Дараагийн асуудалд оръё.

Дөрөв.Төрийн албаны зөвлөлийн 2019, 2020 оны үйл ажиллагааны тайлан

Төрийн албаны зөвлөлийн 2019, 2020 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж эхэлье.

Та бүхэндээ ажлын хэсгийг танилцуулъя. Б.Баатарзориг Төрийн албаны зөвлөлийн дарга, Д.Зүмбэрэлхам Төрийн албаны зөвлөлийн гишүүн, С.Цэдэндамба Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Д.Баатарсайхан Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Б.Идэрчулуун Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Т.Сосорбарам Төрийн албаны зөвлөлийн Сонгон шалгаруулалтын газрын дарга, Я.Хишигт Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн удирдлага, аудитын газрын дарга, Л.Санжрагчаа Төрийн албаны зөвлөлийн Сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн газрын хэлтсийн дарга, Л.Лхамжав Төрийн албаны зөвлөлийн Сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн газрын ахлах референт, Ж.Жамъянтив Төрийн албаны зөвлөлийн Стратегийн төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлага хариуцсан ахлах референт, Э.Мөнхгэрэл Төрийн албаны зөвлөлийн Маргаан хянан шийдвэрлэх газрын Төрд учруулсан хохирол хариуцсан референт, Э.Золбоо Төрийн албаны зөвлөлийн Сонгон шалгаруулалтын газрын референт, Ц.Галбадрах Төрийн албаны зөвлөлийн Сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн газрын Төрийн албаны улсын нэгдсэн тоо бүртгэлийн хөтлөлт хариуцсан референт, Д.Дэмчигсүрэн Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны зөвлөх, Д.Энхтулга Төрийн албаны зөвлөлийн ажилтан, н.Ууганбаяр Төрийн албаны зөвлөлийн хэвлэлийн ажилтан гэсэн ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Байнгын хороо Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.5-д эрхлэх асуудлын хүрээнд холбогдох Засгийн газрын гишүүний мэдээлэл, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тайлан

мэдээллийг сонсоно гэсэн хуулийн зохицуулалт заалттай. Энэ хүрээнд өнөөдөр Төрийн албаны зөвлөлийн ажлын тайланг сонсож байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын, Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын ажлын тайланг сонсдог. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн тухайн жилийн хэрэгжилтийг бас Төрийн байгуулалтын байнгын хороон дээр тайланг нь сонсдог. Ийм хуулийн зохицуулалттай.

Төрийн албаны зөвлөлийн 2019, 2020 оны үйл ажиллагааны тайланг Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг танилцуулна.

4 дүгээр микрофоныг өгье.

Б.Баатарзориг: Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороон дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Төрийн албаны зөвлөлийн 2019, 2020 оны үйл ажиллагааны тайланд Та бүхнийг анхаарлаа хандуулахыг хүсье.

Төрийн албаны тухай хууль шинэчлэн батлагдсанаар төрийн албаны шинэтгэлийн шинэ үеийн бодлого, стратеги тодорхой болсон. Тогтвортой, хариуцлагатай, мэргэшсэн, улс төрөөс ангид байх зарчмыг олон нийтэд ойлгуулж, хэрэгжүүлж, үр дүнд хүргэх нь шинэтгэлд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, дэмжлэг, хөрс болгох зорилт тавьсан юм.

Иргэд болон төрийн албан хаагч гэсэн хоёр үндсэн чиглэлээр шинэ хууль, шинэтгэлийн бодлогыг сурталчлах, соён гэгээрүүлэх ажлыг бүх аймаг, нийслэл, сум, дүүрэг, бүх шатны байгууллага, салбар бүрийн төлөөлөлд хүргэх ажлыг зохион байгуулсан.

Зохион байгуулахдаа зайны болон танхимын сургалт, семинар, хэлэлцүүлэг, үндэсний зөвлөгөөн, нүүр тулсан уулзалт, ярилцлагыг олон хэлбэрээр нийгмийн сүлжээний олон аргаар зохион байгууллаа.

Үүний үр дүнд хууль дээдлэх концепц, нийгэмд эрх зүйн соёл, төлөвших мерит зарчим, карьерын тогтолцоо бүхий шинэ цагийн төрийн албаны шинэ ойлголт, шинэ хандлага, шинэ итгэлийн үзэл санаа бүрэлдэж, өөрчлөлт шинэчлэлтийг шударга ёсны хүлээлт, хүсэмжлэл бий болсон юм.

2021 оны 01 сарын 01-ний байдлаар төрийн албаны бүрэлдэхүүний тоо мэдээллийг Та бүхэнд маш товчхон байдлаар танилцуулъя.

Төрийн 4 мянга 147 байгууллагад 205 мянган албан хаагч ажиллаж байна.

Өмнөх онтой харьцуулбал албан хаагчдын тоо маань нэмэгдсэн. 3.2 хувь буюу 6548 албан хаагчдаар нэмэгдсэн. Нэмэгдсэн үндэслэл нь иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулахтай холбоотой, өргөжүүлэхтэй холбоотой, эмнэлэг, сургууль, онцгой байдлын зарим анги, салбарууд нэмэгдсэнтэй холбоотойгоор үйл ажиллагаа өргөжсөнтэйгөөр нэмэгдсэн.

Нийт төрийн албан хаагчдын 2.0 хувийг улс төрийн албан хаагч, 10.0 хувийг төрийн захиргааны албан хаагч, 22.0 хувийг төрийн тусгай албан хаагч, 66.0 хувийг төрийн үйлчилгээний албан хаагч эзэлж байгаа юм.

Төрийн албаны шинэтгэлийн хүрээнд бид 2019 онд 19 онцлох зорилт, 2020 онд 20 онцлох зорилт дэвшүүлэн ажиллалаа. Энэ талаар дэлгэцэн дээр харагдаж байгаа.

Нэг. Хүний нөөцийн удирдлага, аудитын талаар.

Төрийн албаны тухай хууль тогтоомж чадахуйн зарчмын хэрэгжилтэд шинээр нэвтрүүлж байгаа хүний нөөцийн аудитыг үе шаттай хэрэгжүүлж байна.

Олон улсын болон үндэстний мэргэшсэн байгууллага, судлаач, эрдэмтэдтэй хамтран хүний нөөцийн аудитын шинэ гарын авлагыг түгээн дэлгэрүүлж, хэрэгжүүлэх ажлыг эхлүүлээд байна. Төрийн байгууллагын хүний нөөцийн удирдлагын бүхий л үе шатанд үнэлгээ хийж, эрсдэл тодорхойлж, давуу, сул талыг оношилж эрсдэлээс сэргийлэх, зөвлөмжөөр хангах бэлтгэл ажлуудыг мөн хийлээ.

Хүний нөөцийн аудитын дүнг Төрийн байгуулалтын байнгын хороонд цаашдаа тухай бүр танилцуулж, зөвлөмж, чиглэл авч хэрэгжилтийг ханган ажиллах болно.

Албан тушаалын тодорхойлолтод тулгуурласан шинэчлэл эрчимжлээ, мерит зарчим, шатлан дэвшүүлэх тогтолцоо бүхий төрийн албыг төлөвших үндсэн нөхцөл нь хуулийн шаардлагад нийцсэн албан тушаалын тодорхойлолтыг баталж мөрдүүлэх явдал юм.

Энэ чиглэлд онцгой анхаарч, төрийн захиргааны удирдах, гүйцэтгэх болон төрийн үйлчилгээний удирдах нийт 22 мянга 50 албан тушаалтны тодорхойлолтыг баталлаа. Стандарттай боллоо. Доод жишиг шаардлагатай боллоо.

Ингэснээр төрийн захиргааны албан тушаал бүрийн зорилго, зорилт, чиг үүрэг, хэрэгжүүлэх албан хаагчид тавигдах үндсэн шаардлага, үүрэг, хариуцлага тодорхой болж, зураглал баталгаажиг байгаа юм.

Албан тушаалын тодорхойлолт нь тухайн албан тушаалд сонгон шалгаруулалт явуулах, томилгоо хийх, хяналт хийх үндсэн баримт бичиг юм.

Хүний нөөцийн хүрээг бүхэлд нь багтаасан суурь судалгааг Дундговь аймгийн жишээн дээр хийж, бусад аймгуудад түгээн дэлгэрүүлж байна.

Өмнө нь Төрийн албаны зөвлөлөөс бусад байгууллагуудаас яг энэ чиглэлээр суурь судалгаа хийж байсан зүйл ховор байдаг. Шинэтгэлийн нэг чиглэл бол судалгаанд үндэслэсэн шийдвэр гаргах явдал байлаа.

Төрийн албаны ерөнхий шалгалтыг тогтмол авах боломж, бэлтгэлийг хангаж байна. Төрийн албаны нөөц бүрдүүлэх ерөнхий шалгалтыг технологийн дэвшилд ашиглан зохион байгуулж байгаа. Уг шалгалтад бэлтгэл ажлын хүрээнд өмнө нь учир дутагдал байсан. Үүнийг үе шаттай зассан. Шалгалтад иргэд бие даан бэлтгэх цахим суурь үүсгэсэн. Тэгш, хүртээмжтэй байх нөхцөлийг бүрдүүлж байна. Мэдлэг чадвараа урьдчилан сорих боломжийг хангаж өгсөн.

Төрийн албаны ерөнхий шалгалтыг 2019, 2020 онд 27 мянга 383 иргэн оролцсон. 7 мянга 254 иргэн тэнцээд байгаа. Нөөцөд байгаа. Шинжлэх ухааны академи, эрдэмтэд судлаачид, төрийн албан хаагчдын өөрсдийн оролцоотойгоор шалгалтын сорилт тестийн агуулгыг баяжуулсан. Мэргэжлийн байгууллагуудыг татан оролцуулсан. Тестийн сангийн өгөгдлийг нэмэгдүүлсэн. Одоо тест болон агуулга дээр шүүмжлэл гардаггүй. Е-тааз аппликэйшн хөгжүүлж тестийг хэвлэмэл болон онлайн хэлбэрээр гар утаснаас нийгмийн сүлжээнд нээлттэй тавьсан. Үнэ төлбөргүй болгосон. Тэгш хүртээмжтэй, ил тод болгосон. Шалгалтын бүхий л процессыг 100 хувь технологижуулж байна.

Чадахуйн зарчмыг хангасан шударга сонгон шалгаруулалтыг авах эхлэл тавигдлаа. Төрийн албаны жинхэнэ албаны удирдах албан тушаалын 548, гүйцэтгэх албан тушаалын 2 мянга 435 сул орон тоонд сонгон шалгаруулалт зохион байгуулж, шатлан дэвших зарчмыг мөрдөн ажиллаж байна.

Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн 343 албан тушаалын сонгон шалгаруулалтыг зарлаж, давхардсан тоогоор 483 иргэн сонгон шалгаруулалтад орж, зарлагдсан сул орон тоо үе шаттай нөхөгдөж байгаа. Нөхөгдөөгүй сул орон тоонуудад бас байгаа. КОВИД-ын хуультай холбоотой олон сорилтууд тулгарч байна.

Хоёр. Ёс зүй, сахилга хариуцлага, хяналтын талаар.

Ёс зүй, сахилга хариуцлагад тулгуурласан шинэ итгэлийг эхлүүлээ.

Төрийн албаны ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулах тухай зөвлөмж гаргаж, төрийн албан тушаал хаагчдын ёс зүйн хэмжээг сахиулах, сахилга хариуцлагыг сайжруулах, урьдчилан сэргийлэх, өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавих чиглэлээр тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Нийт 1194 төрийн байгууллагад “ёс зүйн зөвлөл” ажиллаж байгаа. 1422 төрийн албан хаагч ёс зүйн зөрчил гаргасан. 800 нь үүнээс төрийн тусгай албан хаагч, 353 төрийн захиргааны албан хаагч, 26 нь төрийн үйлчилгээний албан хаагч байгаа юм.

2020 онд 371 төрийн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан. 62-т нь сануулах, 180-д нь цалингийн хэмжээг 20 хүртэл хувиар бууруулах, 29-д нь төрийн албанаас халах сахилгын шийтгэлийг хүлээлгэсэн.

Төрийн байгууллагуудын ёс зүйн зөвлөлүүдийн нэгдсэн зөвлөгөөнийг “Итгэл даах төрийн албаны төлөө” сэдэвтэйгээр Улсын Их Хурлын Тамгын газартай хамтран зохион байгуулсан.

Шинэтгэлийн хүрээнд маргаан шийдвэрлэж, төрийн албан хаагчдын эрхийг хамгаалан ажиллалаа. Төрийн албаны зөвлөл төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаатай холбоотой, Төрийн албан хаагч төрийн албанд нэр дэвшигчийн эрх зөрчигдсөнтэй холбоотой 445 өргөдөл, гомдол, мэдээлэл ирсэн. Өмнөх онуудаас энэ мэдээлэл гомдлууд өсөж байгаа. 5.2 хувиар өссөн. Шийдвэрлэлт 93.4 хувьтай байна.

Төрийн албанд эрх нь зөрчигдсөн гомдлын мөрөөр 22 маргаан үүсгэж, хууль зөрчсөн тушаал шийдвэрийг хүчингүй болгосон.

Төрийн албанаас хууль бусаар халагдсан, албан тушаал нь буурсан албан хаагчдыг эрхэлж байсан албан тушаалд нь томилох зэргээр 195 гомдлыг шийдвэрлэсэн.

Төрийн албанаас хууль бусаар халагдсан, чөлөөлөгдсөн албан тушаал бууруулсан 14 албан хаагчийг Төрийн албаны зөвлөлийн шийдвэрээр урьд эрхэлж байсан ажил, албан тушаалд нь томилсон.

Өргөдөлд тулгуурласан шинэтгэлийг эхэллээ. Өгөгдөлд, датад тулгуурласан. Төрийн албанд 3 жилийн хугацаанд эргэн орохгүйгээр халагдсан, нийтийн албанд ажиллах эрх нь хасагдсан, шүүхийн шийдвэрээр авлига, албан тушаалын гэмт хэрэгт ял шийтгэгдсэн этгээдийн бүртгэл, мэдээллийн санг шинээр бүрдүүлж, төрийн албанд томилогдох байдал дээр нь хориг тавьж, хяналт тавьж ажиллаж байна.

Гурав. Төрийн албаны цахим шинэчлэлтийн талаар.

Төрийн албан хаагчдын сургалт, хөгжлийг дэмжихээр ажиллаж байна.

Төрийн албан хаагчдын сургалт, хөгжлийн үндэсний тогтолцоог шинээр бүрдүүллээ. Мэргэшүүлэх багц, төрийн албанд анх орох, томилогдсон албан хаагчдыг чиглүүлэх, богино хугацааны мэргэшүүлэх, дунд хугацааны давтан сургалт, зорилт, богино хугацааны сургалтад 5465 төрийн албан хаагч хамрагдаад байна.

Яам, агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүргийн 525 төрийн байгууллагад арга зүйн сургалтуудыг зохион байгууллаа. 20 мянга гаруй албан хаагчийг хамруулсан. Хүний нөөцийн мэдээллийн системийн суурийг бэхжүүллээ.

Хүний нөөцийн удирдлагын системийг Сангийн яамны цалингийн нэгдсэн системтэй холбосноор 4355 байгууллагын 182 мянган төрийн албан хаагчийн цалин хөлсийг Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн системд үндэслэн тооцон олгодог боллоо.

Орон тооны төлөвлөлт, хэрэгжилтэд хяналт тавьж болж байна. Илүү орон тоогоор ажиллуулж байгаа хүмүүсийг хянаж болж байна. Одоо цаашаагаа хууль бус томилгоог хянах, цалинтай нь уялдуулах, шинэтгэлийг эдийн засгийн агуулгатай болгох эхлэл тавигдаж байгаа юм.

Эрхэм дарга, гишүүд ээ.

Шинэтгэлийн инновацыг хөгжүүлэх талаарх Дөрөвдүгээр бүлэгт оръё.

Инновацид хөтлөгдсөн төрийн албыг төлөвшүүлэх чухал зорилтыг тавьж байгаа. Энэ чиглэлээр хүний нөөцийн меритийн, мотивацийн суурь судалгаануудыг, хавсарга судалгаануудыг хийсэн. Үр дүнг төрийн байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлж байгаа.

2003 оноос хойш төрийн албаны чиглэлээр хийгдсэн бүх судалгааг нэгтгэж шийдвэр гаргах түвшинд ашиглагдаж байна.

Бодлогын инновацийн шийдвэр боловсруулах үр дүнтэй арга зүйг эргэлтэд оруулах зорилгоор яам, агентлаг, аймаг, нийслэлийн санаачлан боловсруулсан инновацийн 20 төслийг сонгон шалгаруулж, үр дүнг санхүүжүүлж байгаа. Яг Төрийн

албаны зөвлөл биш. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилтээр инновацын мастеруудыг тодруулах, инновацыг дэмжихтэй холбоотой үйл ажиллагаа явуулж байгаа юм.

Хувийн хэвшлийн менежментийн дэвшилт арга туршлагыг төрийн албанд нэвтрүүлэх ажлуудыг эхлүүлсэн. Шилдэг мэргэжилтнүүдийг төрийн албанд урин ажиллуулах, байгууллага салбарын үйл ажиллагааг том зургаар нь харж зорилго зорилтоо тодорхойлон удирдах, карьер хөгжлийн зураглалыг хэрэгжүүлэх, цахим засаглал, хиймэл оюун ухаан, бүх талын оролцоотой үнэлгээний систем зэрэг, менежментийн шинэ орчныг төрийн албанд нэвтрүүлж байгаа.

КОВИД-той холбоотой зарим бэрхшээлүүд учирсан. Төлөвлөж байсан, тогтож байсан урьдчилан томьёолсон зарим зүйлүүд дээр бэрхшээл учирсан. Бас давуу тал ч бий болсон. КОВИД-той холбоотойгоор төрийн байгууллагуудын үйл ажиллагааны хэвийн, тасралтгүй байдлыг хангахад онцгойлон анхаарсан. Шинэ үзэгдэл байсан учраас олон улсын нөхцөл байдал, сорилт, үр дагавар, хандлага, Английн эрдэмтдийн судалгаа, Бүгд Найрамдах Солонгос Улсын төрийн байгууллагуудаас цар тахалтай тэмцэж байгаа ажлын хүрээ, туршлагууд, зөвлөмжүүдийг авч түгээн дэлгэрүүлсэн.

Энэ дээр иргэд, төрийн байгууллагууд нэлээн эрэлт хэрэгцээтэй байдаг юм. Хүлээлттэй байдаг юм.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын хөгжлийн хөтөлбөртэй хамтраад илүү сайхан ирээдүйг бүтээх нь зөвлөх хорооны цуврал уулзалтыг зохион байгуулсан.

Шинэлэг логик системийн хувьслын аргачлалаар тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх боломж гарцуудыг зөвлөлдсөн. Хэрэгжүүлж хэвшүүлсэн ажлуудыг товч дүгнэе.

Нэгдүгээрт нь, төрийн албаны шинэтгэлийн стратеги, замын зургийг бодлогын хүрээнд тодорхойлсон. Нэг хавтгай дээр оруулсан. Өгөгдлүүдийг нэгтгэсэн. Институцийн төлөвшил, хөгжлийг бий болгож, үе шаттай үр дүн гарах эх л тавигдсан.

Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэхэд нэмэх шаардлагатай 47 журам, дүрмийг Улсын Их Хурал, Засгийн газартай хамтран шинээр боловсруулж, мөрдүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Хоёрдугаарт нь, төрийн албаны тухай хуульд нийцүүлэн боловсронгуй болгох, уялдааг хангах зорилгоор 457 хуульд, үүн дотроос 19 хуулийн зүйл, хэсэг, заалтад өөрчлөлт оруулах, 23 хуулийн зүйл, хэсэг, заалтын нэр, томьёо зөрчлийг арилгах, 17 хуулийн эшлэлд техникийн өөрчлөлт оруулах саналыг Байнгын хороондоо, Их Хурлын Тамгын газарт ирүүлээд байна.

Гурав. Шинэтгэлийн зарчимд тавигдаж буй шаардлагыг тусгах, түүнийг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэхэд төрийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг батлах, зөвшөөрөл олгох үйл ажиллагаа чухал хувь нэмрийг орууллаа. Шинэчлэлтийн суурь боллоо.

Мерит зарчим бол урт хугацаанд ажилласнаар нь бус ур чадвар, мэргэжлийн хувьд хүлээн зөвшөөрөгдсөнөөр нь хэрэгжих зарчим гэж энэ ойлголтыг бид баримталж байгаа.

Өчигдөр манай Ё.Баатарбилэг сайд ч бас энэ чиглэл дээр тодорхой зөвлөмжүүдийг бидэнд өгсөн.

Төрийн албаны хөдөлгөгч хүч төрийн албан хаагчдын хүний нөөцийн оновчтой, зохистой бодлогыг зохицуулсан. Төрийн албан хаагчдаа бэлтгэх, сургах, хөгжүүлэх, гүйцэтгэлийн үр дүнг тодорхой болгох энэ системийг нэвтрүүлж байгаа юм.

Хандлага, харилцааны ур чадварыг тодорхойлох сэтгэл зүйн тестийг өөрийн орны онцлог нөхцөл байдалд тохируулан боловсруулах ажил дээр анхаарлаа хандуулсан.

Бодлого, үйл ажиллагааг системтэй өргөнөөр харах, аналитик сэтгэлгээ, оюуны сэтгэлгээний болон сэтгэл хөдлөлийн чадамжуудыг тодорхойлох зэрэг шинэлэг арга зүйг нэвтрүүлэх ажлуудыг эхлүүлээд байгаа.

Тавд нь, төрийн албанд өндөр мэргэжилтэй, мэдлэг, ур чадвартай хүмүүсийг томилоход хуулийн зарим шаардлагуудын босго өндөр байгаа юм. Мөн цалин үнэлэмжийн одоогийн систем ч хязгаарлагдмал байгаа юм. Иймд ажилласан жилийн холбогдох хэсгийг төрийн жинхэнэ албанд ажилласан хугацаатай дүйцүүлэх эрх зүйн орчныг боловсруулах зарчмыг дэмжиж байна.

Цаашид дараах асуудлуудад анхаарлаа хандуулж байгаа. Товч танилцуулъя. Эрхэм дарга, гишүүд ээ,

Нэгдүгээрт нь, төрийн албаны оновчтой бүтэц, үр ашигтай хэмжээг тодорхойлох санал боловсруулах, төрийн албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоох, гүйцэтгэл, үр дүнд суурилсан цалин хөлсний тогтолцоог бий болгох зорилт тавьж байгаа. Энэ дээр санхүүжилтийн дэмжлэг, эх сурвалжийг олсон. Дэлхийн банкнаас иж бүрэн төсөл хэрэгжүүлж, богино хугацаанд энэ дээр санал оруулъя гэсэн.

Төрийн байгуулалтын байнгын хороо Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

Хоёрдугаарт нь, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилт, зөрчлийн талаар дүгнэлт хийж, үндэсний болон олон улсын, төрийн албан хаагчдын ёс зүйн нийтлэг кодыг харьцуулан судалсан байгаа. Энэ талынхаа судалгаа, мэргэжлийн, нөөц, боломжуудыг шинээр батлагдах Төрийн албаны ёс зүй, сахилга хариуцлагын тухай хуульд санал болгон илгээж, тусгуулах чиглэлээр ажиллана.

Гуравдугаарт нь, сонгон шалгаруулалтгүйгээр түр хугацаагаар томилгоо хийх эрхийг КОВИД-ын хуулиар олгосон байдалд дүгнэлт хийж, шаардлага хангаагүй хүмүүсийг томилсон зөрчил дээр шалгалт хамтран хийхээр төлөвлөж байна.

Дөрөвдүгээрт нь, хүний нөөцийн удирдлага, мэдээллийн системийг бусад төрийн байгууллагынхантай холбож, бүрэн цахимжуулах боломж бүрдсэн. Энэ бол бусад төрийн байгууллагуудтай хийх боломжуудыг бүрдээд бэлтгэлийг хангасан.

Цаашид системийг хөгжүүлж дуусгахад технологийн шинэчлэл хийхэд санхүүгийн дэмжлэг, бусад дэмжлэг хэрэгтэй байгаа юм.

Төрийн албаны шинэчлэлийн хүрээнд хийгдэж, дэлгэрэнгүй тайланд тусгагдсан бүхий л үйл ажиллагаа, үр дүн бий болгоход Улсын Их Хурал, Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, Засгийн газрын хамтын хамтын ажиллагаа, зөвлөмж, зөвшилцөл чухал үүрэгтэй байсныг онцлон тэмдэглэе.

Төрийн бүх байгууллагуудын идэвх санаачилга, оролцоотойгоор 2019 он, 2020 оны үйл ажиллагааны тайлан явагдаж байна. Үүнтэй холбоотой товч танилцуулгыг Та бүхэндээ танилцууллаа.

Анхаарал хандуулсанд баярлалаа. Манай холбогдох хүмүүс оролцож байна.

Ж.Мөнхбат: Төрийн албаны зөвлөлийн 2019, 2020 оны үйл ажиллагааны тайлан, танилцуулгыг Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг хийлээ.

Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний хэлтсээс бас санал, дүгнэлт гаргасан. Тайлантай холбогдуулж 2019 оных дээр нь.

Төрийн албаны зөвлөл нь хуулиар тогтоосон чиг үүргийнхээ хүрээнд дэвшүүлсэн зорилтоо бүрэн хэрэгжүүлж ажилласан байна. Үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийн явцтай холбогдуулан дараах саналыг гаргаж байна. Үүнд,

Нэгдүгээрт. Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсан. Мөн төрийн албыг дэлхийн стандартад нийцсэн шинэлэг, үр дүнтэй, төрийн жинхэнэ алба байлгахад нөлөөлж байгаа төрийн албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлөх, үүнтэй холбоотой гарсан маргааныг шийдвэрлэн шүүхээс тогтоосон шийдвэрийг хэрэгжүүлэхгүй байгаа, түүнчлэн уг асуудалтай холбоотой нөхөн төлбөрийн асуудал үүсэх зэрэг асуудлыг үүсгэхгүй байхад анхаарч, хууль зөрчин гаргасан халах, томилох, шийдвэрийг гарсны дараа бус гарахаас нь өмнө хянадаг байх боломж, арга зүйг Төрийн албаны зөвлөлөөс судлан хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

Хоёрдугаарт. Хүний нөөцийн аудитор нь ажилтныг шаардлагатай сургалтад хамруулж, чадавхжуулан зохих албан тушаалд ажиллах нөхцөлөөр хангахад туслах, ажилтны чадавхыг тогтоох чадвартай, мэргэшсэн албан тушаалтан байх гэсэн олон улсын үндсэн стандарт, зарчимд нийцсэн жинхэнэ хүний нөөцийн аудитор бэлтгэхэд Төрийн албаны зөвлөлөөс анхаарч ажиллах нь зүйтэй байна гэсэн Улсын Их Хурлын Тамгын газрын хяналт шалгалт, үнэлгээний хэлтсээс 2019 оны тайланд санал, дүгнэлт гаргасан байгаа.

Мөн 2020 оны тайланд мөн Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газраас санал, дүгнэлт гаргасан.

Нэгдүгээрт. Төрийн албаны зөвлөл нь байгууллагын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийх аргачлалын дагуу үйл ажиллагааны тайландаа гаднын буюу шинжээчдийн үнэлгээ хийж ирүүлсэн байна.

Хоёрдугаарт. Системчилсэн үнэлгээ хийхдээ тухайн жилийн үйл ажиллагааг өмнөх онтой харьцуулсан байдлаар дүгнэж, дэвшилттэй болон цаашид сайжруулах, анхаарах асуудлуудыг чиглэл тус бүрээр тодорхойлон гаргаж, шаардлагатай зөвлөмжүүд өгсөн байгааг 2021 оны үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй байна.

Гуравдугаарт. Төрийн албаны тухай хуульд нийцсэн хуульд заасан чадахуйн зарчмыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд олон улсын стандартад нийцсэн хүний нөөцийн аудитор буюу олон улсын стандартад нийцсэн ажлын байрны шинжилгээ, оношилгоо хийж, зөв тодорхойлогдсон ажлын байранд тохирох ажилтныг ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэн мэргэжлийн болон суурь ур чадварын түвшнийг үнэлж шаардлагатай сургалтад хамруулан чадавхжуулж зохих албан тушаалд ажиллах нөхцөлөөр хангахад туслах, ажилтны чадавхыг зөв тогтоох чадвартай, мэргэшсэн албан тушаалтан бэлдэх тогтолцоог бий болгох замаар төрийн албан хаагчийг чадавхжуулах үйл ажиллагааг эрчимжүүлэхэд анхаарч ажиллах нь зүйтэй байна гэсэн санал, дүгнэлтийг гаргасан байна.

Ингээд Төрийн албаны зөвлөлийн 2019, 2020 оны үйл ажиллагааны тайлантай холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Цахимаар байна уу? Танхимд Ё.Баатарбилэг гишүүнээр тасаллаа. Цахимаар байна уу? Б.Пүрэвдорж гишүүн асууж.

Б.Пүрэвдорж: Төрийн албаны зөвлөлийн тайлан болон Улсын Их Хурлын Хяналт шалгалтын хэлтсийн дүгнэлттэй танилцлаа.

Бүх л юм их гоё болж байгаа юм байна. Тэгэхдээ хажуугаар нь бас асуудлууд байгаа гэдгийг, нуусан юмнууд байгаа гэдгийг хэлье.

Тэгэхээр ер нь төрийн яамдад ажлын чадвартай хүмүүс, газар байгууллагууд бол их муудсан. Чадвартай хүмүүсийг нь солиод дууссан. Намын томилгоогоор олон хүмүүс орж ирсэн.

Ер нь нэг яамны арван хүн дотор нэг сайн чадвартай нэг хоёрхон л хүн байгаа. Тэр дээр нь бүх ажлууд нь явдаг. Бүх зүйлээ мэддэг. Үүх түүхээ мэддэг. Тэр байгууллагын мэргэжилтнээс нь эхлүүлээд ахлах мэргэжилтэн болтол ингээд явчихсан.

Тэгээд бүх ажлыг нь тэр хүмүүс л нугалдаг юм. Тэгээд бусад хүмүүс нь юу байдаг юм, энэ дарга нарын хамаатан садан, тэгээд л юу байдаг юм, намд явсан цүнх баригчид энэ тэр гээд л.

Сонгуулийн үзүүрт ажилласан тэр хүмүүс нь л бүгдээрээ ажилд орчихсон. Тэгээд тэд нар нь ерөөсөө чадвар байхгүй. Тэгээд сонгуульд томоохон менежерээр ажилласан хүмүүс нь шууд нөгөө мерит зарчмаар за би удахгүй нэг ахлах мэргэжилтэн болно доо. Би удахгүй газрын дарга болно доо гэж бодож байсан тэр хүмүүсийн дээгүүр шууд алхаж орж ирээд л томилогддог. Ийм л болчихоод байгаа юм.

Тэгээд энэ КОВИД-ын хуулиар төрийн албан хаагчийг шууд томилдог болсон.

Ж.Мөнхбат: Б.Пүрэвдорж гишүүнд 1 минут нэмж өгье.

Б.Пүрэвдорж: Энэ бүр тэр төрийн албан хаагч нарыг үнэхээр дургүйцлийг нь төрүүлсэн ийм хууль болчихоод байгаа юм. Үүнийгээ хэзээ болих юм бэ?

Ер нь төрийн албан хаагч нар олон жил яам, Тамгын газарт мэргэжилтнээр ажилласан төрийн албан хаагч нар энд чинь маш дургүй байгаа шүү дээ. Тэгээд юу ч мэдэхгүй, юу ч хийж чадахгүй ийм чадваргүй нөхдүүд төрд ажиллаж байгаа

нөхдүүд орж ирээд л, тэгээд л тэр мерит зарчмаар ахина даа гэж бодож байсан тэр төрийн албан хаагч нарын дээгүүр нь ороод л ингээд л явдаг.

Энэ КОВИД-ын хуулиа болихгүй бол. Та нарын тоогоор бол далан хэдэн хүн л томилогдсон гэж ярьж байгаа юм. Шинээр орсон. Тэрнээс ч их байгаа. Та нар тоогоо дарж байгаа. 700 хүн шууд албан тушаал дээшилсэн гэж Та нарын тоон дотор байгаа. Тэр бас биш. Энэ КОВИД-ын хуулиар шууд томилдог төрийн алба.../минут дуусав/

Ж.Мөнхбат: Хэн хариулах билээ? Хоёрдугаар микрофон. Төрийн албаны зөвлөл Д.Зүмбэрэллхам Төрийн албаны зөвлөлийн гишүүн.

Д.Зүмбэрэллхам: Б.Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя.

Төрийн албаны шинэчилсэн найруулгыг 2019 оны 01 сарын 01-нээс эхэлж дагаж мөрдсөн. 2019 онд КОВИД-ын нөхцөл байдал гайгүй байх үед Төрийн албаны зөвлөл бүх төрийн албан хаагчдад хүрч ажиллаж, хуулийн дагуу шаардлага тавьж сонгон шалгаруулалтыг явуулсан.

Төрийн албаны зөвлөлийн сонгон шалгаруулалтаар орж томилогдсон бүх улсууд Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгад заасан тусгай шаардлагыг 100 хувь хангасан улсууд томилогдсон. Өөрөөр хэлэх юм бол доод албан тушаал дээрээ хангалттай жил ажилласан. Бүх төрийн албанд ажилласан хугацаагаараа шаардлага хангасан ийм улсуудыг бид томилсон.

2020 оны эхэнд КОВИД-ын хууль батлагдсан. КОВИД-ын гэж нэрлэгдэж байгаа хууль батлагдсан. Энэ хуулийн 3.2-т албан тушаалын томилгоонд сонгон шалгаруулалт шаардсан заалтыг энэ хуулийг үйлчилж байхад хэрэглэхгүй гэсэн ийм заалт орж ирсэн.

Энэ КОВИД-ын хуулийг батлахад Төрийн албаны зөвлөл санаачлаагүй. Энэ заалтыг. Төрийн албаны зөвлөл энэ дээр санал өгөөгүй. Яг ийм зүйлийг баталъя гэдэг дээр.

Үнэхээр Төрийн албаны зөвлөл одоо энэ хуулийг хэрэгжүүлэхэд Б.Пүрэвдорж гишүүнтэй санал нэг байна. Хуулийг хэрэгжүүлэхэд нэлээн хүчийг сулруулсан. Ямар КОВИД-ын хуулийг барих вэ, төрийн албаны хуулийг барих уу гэдэг ацан шалаанд оруулсан. Ийм нөхцөл байдалтай болгосныг бодитой гэж үзэж байна.

Бид тоо дарах шаардлага.../минут дуусав/

Ж.Мөнхбат: Түрүүн өгчихсөн дөө. Та дэгийн тухай хуулиар цахимаар 2 минут, нэмэлт 1 минут. Үг хэлж болно. Дэгийн тухай хуулиар энгийн горимоор явж байвал 4 минут, хоёр хоёр минут. Үг дээрээ хэлчих.

Би дэг зөрчсөн цэцэд очих хэрэг гарна л даа. 1 минут нэмж өгье.

Б.Пүрэвдорж: Төрийн албаны зөвлөлийнхөн. Үнэхээр Та нарын ажилд саад болж байгаа. Энэ КОВИД-ын хууль.

Тэгэхлээр КОВИД-ын хуулийг сая сунгасан бас үндсэн шалтгааны нэг бол нөгөө нэг дэвшүүлэн томилсон 700-гаад хүн, шинээр ажилд орсон далан гэдэг хүнийгээ энэ ажил дээр нь авч үлдэх гэж энэ хуулийг сунгасан байхгүй юу. Өөрөөр

хэлбэл хамаатан саднаа Монгол Ардын намынхан төрийн албанд чигжсэн. Дэвшүүлэн томилсон.

Энэ зүйлийгээ л үргэлжлүүлэх гэж энэ КОВИД-ын хуулийг сунгасан юм. Энэ нэг том шалтгаан нь болж байгаа. Тийм учраас ер нь энэ КОВИД-ын хуулийн үйлчлэл дуусангуут тэр нэг хэдэн нөхдүүдийг бүгдийг нь хөөж зайлуулаарай. Тэр төрийн албаны олон жил ажилласан тэр мэргэжилтнүүдийг дээш нь ахиулах, ахлах мэргэжилтэн болгох, газрын дарга болох тэр ажлуудыг сайн хийж өгөөрэй. Тэгж байж төрийн алба илүү чанаржина шүү гэдгээ хэлье. Баярлалаа.

Ж.Мөнхбат: Тийм. Сая КОВИД-ын цар тахлын хуулийг Улсын Их Хурлаар хэлэлцэж хугацааг нь сунгасан.

Тэгээд энэ асуудлыг хэлэлцэж байх үед олон гишүүд өөр өөрийн байр сууриа илэрхийлж байна лээ. Тийм. Манай Байнгын хорооноос Б.Пүрэвдорж нарын гишүүд өөрийн байр сууриа илэрхийлж байсан.

Тэгээд энэ Төрийн албаны тухай хууль хэрэгжихэд яах вэ дэлхийгээрээ цар тахлын хүнд нөхцөл байдалтай байгааг бид бүхэн ойлгож байгаа.

Цаашдаа манай Төрийн албаны зөвлөл КОВИД-ын хугацаа дуусна. Энэ хуулийн хугацаа бас дуусна. Тийм учраас Төрийн албаны хуульдаа нийцүүлэх энэ ажил алхмуудыг бас нэн яаралтай хийгээрэй гэдгийг өчигдөр Төрийн албаны зөвлөл дээр ажиллахдаа анхааруулж чиглэл өгсөн байгаа. Үүнийг нэн тэргүүнд анхааралдаа авч ажиллаарай Та бүхэн маань.

Ингээд Ё.Баатарбилэг гишүүн асууя.

Ё.Баатарбилэг: Та бүхнийхээ энэ өдрийн амрыг айлтгая. Би хоёр, гурван зүйл асууя. Энэ тайлангаас.

2020 оны тайланд төрийн тусгай албан хаагчаар ажиллаж байгаа албан хаагчдын тоо 6886 буюу 17.9 хувиар нэмэгдсэн дүн гарсан гэх юм. Энэ одоо ямар учиртай. Төрийн тусгай албан хаагчийг чинь ийм олноороо. Бараг 20-иод хувиар нэмэгдсэн тоо гараад ирсэн байх юм. Үүнийг хариулаад өгөөч.

Дараагийнх нь тайланд байж байгаа Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль байхгүй гэж байна л даа. Төрийн албаны тухай хуулийн 40 дүгээр зүйл дээр ингээд төр албан хаагчийн ёс зүй юу байхгүй гээд.

Энэ намрын чуулганаар Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагын тухай хуулийн төсө, Төрийн жинхэнэ албанд чадахуйц үндэслэн сонгон шалгаруулах хуулийн төсөл гээд хоёр хуулийн төсөл өнөөдөр сая Төрийн байгуулалтын байнгын хороогоор намрын чуулганы хэлэлцэх асуудлын жагсаалт баталчихсан.

Тэгэхээр энэ ёс зүйн асуудлыг би нөгөө өчигдөр бас Та бүхэнтэй уулзахдаа яриад байгаа. Төрийн тусгай албан хаагчдынхаа асуудал дээр нэг жаахан онцгой анхаарч, энэ ёс зүйн асуудал. Төрийн тусгай албан хаагчдыг нэг жаахан онцгой анхаарч ажилладаг л болмоор байгаа юм л даа.

Тэгэхээр энэ ёс зүйн хуультай холбоотой, яг энэ төрийн тусгай албан хаагчдын ёс зүйтэй холбоотой Төрийн албаны зөвлөлд ер нь гомдол санал ирдэг юм байдаг юм уу, үгүй юм уу? Энэ чинь одоо ингээд төрийн тусгай албан хаагч

гэхээр зөвхөн байгууллагаараа тусгай албаараа ингээд явчихдаг юм уу? Эсвэл Та бүхэн рүү ирдэг үү? Одоо энэ олон нийтийн сүлжээгээр гарч байгаа энэ цагдаа иргэдтэй зохисгүй харьцаж байгаа ч гэдэг юм уу, ингээд л нэг юмнууд явах юм.

Тэгэхээр ийм юмнууд танайхаар ордог уу, үгүй юу гэдэг нэг ийм нэг асуулт байна.

1 минут нэмээд авчихъя. Дарга аа. Дараагийнх нь энэ хууль бус халж байгаа, сольж байгаа юмтай холбоотой. Ерөөсөө л нөгөө хариуцлагын асуудал сул болохоор л тэгээд байгаа юм л даа.

Хууль бус халлаа. Эргээд хууль бус гэдгээ мэдэж томилж байгаа шүү дээ. Томилж байгаа дарга. Томилж байгаа даргаар буцааж төлүүлдэг энэ юм нь зүгээр жаахан сул байгаад байна уу. Төрийн албаны зөвлөлийн араа шүд нь арай хүрэхгүй байгаад байгаа юм уу. Ерөөсөө л зоригтой хусаад байх юм. Энэ нэг хурган дарга нар.

Тэгээд эргээд тэрийг нь буцаагаад төлүүлдэг юмыг нь яг баталгаатай л хийдэг болчихвол тэгээд бас нэг шийдвэр гаргахдаа нэг эргэж бодох байлгүй дээ, энэ чинь одоо. Яг үүн дээр хууль эрх зүйн талаасаа юм байна уу, үгүй юу? Үүнийг нэг тодруулаач.

Нөгөө талаасаа энэ төрийн албан хаагчдаа нэг жаахан хамгаалдаг, өмгөөлдөг юмнууд бас баймаар байх юм. Юу гээд хэлж байгаа вэ гэхээр төрийн албан хаагчдыг зүй бусаар доромжлох, ажлын байран дээр нь дарамтлах, зүгээр энгийн иргэн орж ирээд ажлыг нь хийлгэхгүй байх ийм юмнууд дээр Төрийн албаны зөвлөл дуугарахгүй юм.

Ж.Мөнхбат: Хариулъя. Хэддүгээр микрофон байна. 5 уу?

Төрийн албаны зөвлөлийн гишүүн Б.Идэрчулуун.

Б.Идэрчулуун: Баярлалаа. Би Ё.Баатарбилэг гишүүний хоёр асуултад хариулъя.

Эхнийх нь бол төрийн албан хаагчийн ёс зүйн асуудалтай холбоотой гэж.

Бид төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмээр зохицуулагдаж байгаа харилцаанууд Төрийн албаны зөвлөлд гомдол, маргаан болоод ирдэг юм. Энэ журмаар яаж байна вэ гэхээр тухайн байгууллагын ёс зүйн зөвлөл шийдээд түүнтэй санал нийлэхгүй бол дээд шатных нь байгууллагын ёс зүйн зөвлөлд хандана л гэсэн юм байгаа юм.

Энэ журам бас учир дутагдалтай юм бий. Тухайлбал Төрийн нарийн бичгийн дарга, аймгийн Тамгын дарга ч гэдэг юм уу, одоо энэ тэргүүн түшмэлийн хэмжээний хүмүүсийн гаргасан ёс зүйн асуудлыг үндсэндээ одоо жишээлбэл албатууд нь шийдэх үү. Тэрийг хэн хариуцаж шалгах вэ. Энэ зохицуулалт хоосон үлдчихсэн.

Одоо энэ хуульд харин Байнгын хороотойгоо нийлээн хамтарч ажиллалаа. Энэ ёс зүйн чиглэлээр бид санаа оноогоо солилцье гэж бодож байгаа. Ажлын хэсэгт нь орох бодлого барьж байна.

Цагдаагийн байгууллага, тусгай тусгайгийнхны ёс зүйтэй холбоотой асуудлыг өөр өөрийнх нь хуулийн хүрээнд тэндээ шийдэж байгаа юм. Тэгэхдээ төрийн албан хаагчийнхаа хувьд эрх нь зөрчигдсөн гэж манайд хандаж байгаа. Олноороо ханддаг. Бид энэ асуудлыг нь бас давхар шийдээд явж байгаа юм байгаа.

Дээр нь сая Ё.Баатарбилэг гишүүн хэллээ. Энэ төрийн погонтой улсуудын ёс зүйн зөрчил одоо энэ олон нийт сошиал сүлжээнд тавигддаг. Энэ дээр бид бас давхар хяналт, иргэдийн энэ хяналтыг авч ажиллаж байгаа.

Ж.Мөнхбат: Нэмэлт хугацаа өгье. 5 номер дээр.

Б.Идэрчулуун: Одоо бид бүгдээрээ мэдэж байгаа шүү дээ. Нэг хэвлэл мэдээллийн ажилтан эмэгтэй. Өөрийгөө таньсангүй гэж цагдаагийн албан хаагчид хэрүүл үүсгэсэн. Энэ асуудлаар бид ардаас нь хөөцөлдсөн. Тэр доор нь арга хэмжээ авсан. Ёс зүйгүй харилцаа гаргасан. Нөгөө албан хаагч дээр нь арга хэмжээ авсан. Өөрт нь бас сахилгын арга хэмжээ тооцсон гэх мэт.

Энэ нь бол ингээд явж байгаа. Бид энэ сошиалаар гарч байгаа энэ юун дээр их анхааралтай ажиглаж үүний мөрөөр ажил хийж байгаа.

Хууль бус халснаас улсад учирч байгаа хохирлын асуудал одоо ер нь бол цэгцэлж голдрилд нь оруулахад бас одоохондоо жаахан түвэгтэй байгаа. Тэгэхдээ бид Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, прокурор. Прокурор чинь хуульчилсан. Төрийн нэрийн өмнөөс нэхэмжлэл гаргах байгууллага. Төрд учирсан хохирлыг.

Хоёр дахь нь Төрийн албаны зөвлөл төрд учирсан хохирлыг нэхэмжлэл гаргана. Бүртгэл хөтөлнө. Хяналт тавина гэсэн ийм гурван чиг үүрэг байгаа.

Дээр нь ерөөсөө төрд учирсан хохирол дээр хяналт тавьдаг бие даасан аудитын байгууллага байж байна. Тэгээд одоогоор бид хоёр жил ажиллахад энэ гурван байгууллагын тоо хоорондоо нийлдэггүй. Шийдвэр гүйцэтгэл дээр зарим нь шийдвэр гүйцэтгэлээ барьж аваачиж бүртгүүлдэггүйгээс тэнд тоо бага гарч байна. Зарим хүн тэр төлбөр ялбараа авахгүйгээр шууд хаяад явж байна.

Шийдвэр гүйцэтгэл дээрээс яг шийдэгдээд. Ухаандаа төрөөс мөнгө нь ажилгүй хугацааны цалин олгогдоод ингээд үлдчихсэн дээр бид хамаад маш том судалгаа хийгээд, нэртэй устай нь гаргаад шүүхэд нэхэмжлээд явж байгаа. Энэ бол голдрилдоо ороод эхэлчихсэн байгаа. Түрүүнээсээ төлүүлсэн байгаа. Сайн дураар одоо сайд хийж байгаа хүнийг Та Төрийн нарийн бичгийн дарга хийж байхдаа ийм хууль бус тушаал гаргасан. Энэ чинь шүүхээр тогтоогдоод ингэсэн. Үүнийгээ төлөө гэсэн. Сайн дураараа төлчихсөн тохиолдол хүртэл байгаа.

Одоо бидэнд яах вэ энэ цаасан дээр буусан үнийн дүн бага юм шиг харагдаад байгаа. Тэгэхдээ шүүхийн шатанд явж байгаа, нэхэмжлэлийн шатанд явж байгаа ийм ажлууд байгаа.

Тэгэхдээ бас одоо энэ бидний л алдаа байх. Одоо жишээлбэл шүүх дээр манайх материал бүрдүүлээд өгөхөд зарим аймгийн шүүх бодитой. Өнөөдөр хамгийн сүүлд гарч байгаа кэйс Дундговь аймгийн шүүх нотариатаар батлуулсангүй. Төрийн албаны зөвлөл энэ юмаа нотариатаар батлуулсангүй гээд. Ингээд нэхэмжлэлийг хүлээж авахаас татгалзаж байгаад нэг сумын Засаг даргатай холбоотой ийм юмнууд яваад байна.

Тэгэхээр хаана хаанаа бас анхаарах ёстой асуудал байна. Хуулиа уншдаггүй шүүгч байна.

Хууль хэрэгжиж эхлэхээс өмнөх их том тоо явдаг юм. Энэ төрд учирсан хохирлын гээд. 2019 оны 01 сарын 01-нээс хойших судалгаа тоо бол одоо үндсэндээ цэгцдээ орчхож байгаа. Түүнээс өмнөх нь тэрийг ялгаж салгахад хэцүү. Захиргааны хэргийн шүүхээр бид нэхэмжлээд, Та нар энэ хууль хэрэгжихээс өмнөх юмтай огт хамаагүй гээд шүүх бүр практик тогтоогоод ингээд тасалчихсан асуудал байгаа.

Тэгэхээр 2019 оны 01 сарын 01-нээс өмнөх хууль бус томилгоотой холбоотой, төрд учирсан хохирлыг бид хөндөж чадахгүй хэмжээнд болчихоод байгаа юм.

Ж.Мөнхбат: Гурав дахь асуултад хэн хариулах уу? С.Цэдэндамба Төрийн албаны зөвлөлийн гишүүн. 1 номерын микрофон.

С.Цэдэндамба: Ё.Баатарбилэг гишүүний асуултад хариулъя.

Чухал асуудал хөндөж байна. Ер нь нийт 205 мянга орчим төрийн албан хаагч дотор төрийн захиргаа, төрийн тусгай гэсэн төрийн жинхэнэ албан хаагч нь бол гуравны нэг нь л байдаг. 66 мянга орчим байгаа.

Үүнээс 20 мянган төрийн захиргаа, 45 мянган төрийн тусгай гэсэн ангиллаар явж байгаа. Өөрөөр хэлбэл төрийн захиргаанаас хоёр дахин их болсон. Үүнтэй холбоотой асуулт асууж байна.

Өнгөрсөн оноос 6 мянга гаруйгаар төрийн тусгайгийн албан тушаал нэмэгдсэн нь ямар учиртай вэ гэсэн гэсэн асуулт байлаа. Үүнтэй холбогдуулж хэлэхэд бол яах вэ, төрийн тусгай байгууллага, зарим байгууллагуудын дотоод задаргаа бол хуулиараа нууц байдаг учраас ерөнхий тоогоор ирдэг.

Зүгээр өнгөрсөн хугацаанд ямар ч байсан төрийн тусгай ангиллаар бол хэд хэдэн албан тушаалууд хуулийн дагуу бий болсон. Тухайлбал, экологийн цагдаа бүх газар орон нутагт байж байна. Онцгой байдлыг бас нэмэгдүүлэх. Зарим анги, аймгуудад онцгой байдлын салбар ангиудыг бас байгуулсан. Үүнийг дагаад зохих орон тоо нэмэгдсэн. Мөн нийгмийн дотоод аюулгүй байдал болон харуул хамгаалалттай объектуудыг нэмэгдүүлэх.

Үүнтэй холбоотой дотоодын цэргийн тусгай албан хаагчдын тоо нэмэгдсэн. Ийм байдлууд ажиглагдаж байгаа. Нэмэгдсэн үндэслэл бол ийм байна.

Ер нь сая гишүүний асуусан тэр асуулт бол энэ төрийн захиргаа, төрийн тусгайгийн статус, харьцаа цаашаа ер нь ямар байх вэ, ялангуяа төрийн тусгай албан хаагчдын ёс зүй, хариуцлагын асуудлыг Төрийн албаны зөвлөл анхааралдаа авах уу гэдэг асуудал дэвшүүллээ. Зүйтэй. Тэгэхдээ өнөөдрийн байдлаар бол төрийн албаны үндсэн хуульд.../минут дуусав/

Ж.Мөнхбат: 1 номерын микрофоны хугацааг сунгая. 1 минут.

С.Цэдэндамба: Энд хуулиар тусгайлан зохицуулаагүй бол Төрийн албаны зөвлөл хариуцна гэдэг энэ зарчмаар үндсэндээ төрийн тусгай байгууллагууд тус

тусын хуультай. Түүндээ хариуцлагаа ярьдаг, ангилал, зэрэглэлээ тусгайд нь тогтоодог ийм байдал байгаа.

Үүнийг цааш цаашдын саяын тэр өргөн барьж дэвшүүлсэн ёс зүйн хууль, хариуцлагын хууль, энэ бүхэнд харгалзаж үзэх, нэгдсэн хяналттай болгох энэ чиглэл бол бас зөв зүйтэй санал гэдэг дээр санал нэг байгаагаа илэрхийлье. Баярлалаа.

Ж.Мөнхбат: Тэгэхээр өнөөдөр бид Төрийн байгуулалтын байнгын хороогоор Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн хэлэлцэх эсэхийг шийдэж байна.

Өнөөдөр Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар орно. Төрийн албаны зөвлөл төрийг төлөөлж Улсын Их Хурал төрийн эрх барих дээд байгууллагаас томилогдож энэ Төрийн албаны хуулийн хэрэгжилтийг хянадаг. Энэ дээр сахилга хариуцлага, ёс зүй гээд ингээд сонгон шалгаруулалт бүх зүйл явж байгаа.

Төрийн байгуулалтын байнгын хороо намрын чуулганаар Төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагын тухай хуулийг авч хэлэлцэнэ. Улсын Их Хуралд өргөн барьж байгаа. Сонгон шалгаруулалтын хуулийг авч хэлэлцэнэ. Улсын Их Хуралд өргөн барьж байгаа. Улсын Их Хурлын хяналт шалгалтын хуулийг хаврын чуулганаар бид ингээд хэлэлцээд эхэлж байна. Батална. Чуулган завсарлахаас өмнө.

Тийм учраас энэ хууль батлагдсантай холбогдуулан Улсын Их Хурлын хяналт шалгалтын эрх нээгдэж байгаа. Өнгөрсөн жил батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд оруулсан онцгой бүрэн эрхийн заалтын хүрээнд ингэж энэ асуудал шийдэгдэж байгаа юм.

Тэгээд Төрийн албаны зөвлөл өмнө нь Улсын Их Хурлын хянан шалгалтын үүргийг төрийн байгууллага, төрийн албанд хэрэгжүүлдэг байсан. Цаашдаа энэ хяналт шалгалтын тухай хууль батлагдсанаар Улсын Их Хурал өөрөө хянан шалгах эрхээ эдэлж эхэлнэ. Мөн үүнтэй хамтарч Төрийн албаны зөвлөл хамт ажиллана.

Тэгээд танай эрх байхгүй болж байгаа юм бол биш. Улсын Их Хуралтайгаа хамтарч энэ ажлыг хийх ийм боломж бас нээгдэж байгаа юм.

Сая Ё.Баатарбилэг гишүүн бас асуугаад байна лээ. С.Цэдэндамба Төрийн албаны зөвлөлийн гишүүн хариулж байна. Сүүлийн үед хэвлэл мэдээлэл, энэ сошиал сүлжээгээр төрийн албан хаагчдын ажлаа хийж байгаа хүмүүсийн нэр хүндэд нь халдах, гүтгэх, доромжлох ийм асуудлууд нэлээдгүй гардаг болсон. Үүнийг бид заагтай ялгаатай харах ёстой юм байна лээ. Үнэхээр хариуцлага алдсан, ёс зүйн алдаа гаргасан хүн бол энэ хариуцлагаа хүлээх ёстой. Ёс зүйн алдаа гаргасан бол.

Тийм учраас төрийн албан хаагчдад тавих ёс зүйн сахилга, хариуцлагыг нэмэгдүүлэх ийм хуультай болно. Энэ хуулийг хэрэгжүүлж эхэлснээр, энэ сонгон шалгаруулалтын хуулийг хэрэгжүүлж эхэлснээр манай Төрийн албаны зөвлөлийн. Одоо зөвхөн Төрийн албаны хуулийг мөрдүүлэх л ажил явагдаж байгаа шүү дээ. Төрийн албаны хуулийг зөрчиж байна уу, үгүй юу гэдэг дээр Та бүхэн бас ажиллаж байгаа байх.

Тэгэхээр ийм өргөн боломж, бас эрх, үүрэг хоёр нэмэгдэж байгаа шүү гэдгийг Төрийн албаны зөвлөлийнхөнд хэлье гэж бодож байгаа юм.

Ингээд гишүүд асуулт асуу асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүн байна уу? Цахимаар байна уу? Ё.Баатарбилэг гишүүн асууя.

Ё.Баатарбилэг: Тэгэхээр Төрийн албаны зөвлөлийн энэ тайланг сонслоо. Өмнө нь тараагдсан байсны материалтай танилцсан.

Дөрвөн зүйл дээр Та бүхэн нэг жаахан анхаараад ажиллаадах уу л гэж. Энэ КОВИД-ын цар тахлын хугацааг ашиглаад дотоод үйл ажиллагаа, яг өөрсдөөсөө шалтгаалах бичиг цаасны энэ байгууллагын дотоод болон энэ салбар зөвлөлүүдтэй хамтарч ажиллах, энэ дүрэм журам, заавар батлах, энэ юмнууд дээр маш их цаг хугацааны боломжууд гарч байгаа юм. Одоо олон шалгалтууд байсан. Хойшилсон. Тийм ээ. Та бүхэн орон нутагт явж сургалтууд зохион байгуулдаг. Хойшилсон. Интернет, цахимаар юмнууд явдаг болсон. Энэ цаг хугацаагаа ашиглаад саяын хоёр том хууль дээр саналуудаа бэлтгэх, саяын хууль эрх зүйн орчны юмнууд дээр тулгамдаж байгаа, засах шаардлагатай юмнуудаа янзлах энэ юмнууд руугаа бас шуурхай ороод ажиллачихаасай гэж ингэж бодож байгаа юм.

Хоёрдугаарт, хууль бус халагдсан хүмүүсийнхээ эрх ашгийг хамгаалах, энэ төрийн албан хаагчдынхаа эрх ашгийг хамгаалах тал дээр бас жаахан анхаарч ажилламаар байна. Их удаан байна гээд байна. Сарын дараа шийдвэр нь ирээд байдаг. Шүүхийн шийдвэр нь гарчхаад, бүр бараг буцаад ажилд томилогдсоны, дараа нь Төрийн албаны зөвлөлийн шийдвэр ирж байх жишээний гээд.

Тэгэхээр энэ юмнууд дээрээ Та бүхэн үнэхээр яг юун дээрээ саатаад болдоггүй юм. Үүнийг бол шийдвэрийг нь гаргаад л хууль зөрчсөн, зөрчөөгүй гээд л гаргаад ирмээр л санагдаад байгаа байхгүй юу. Бичгийг нь бол долр нь хариул. Энэ журамдаа Та бүхэн эргэж хараач.

Нөгөө талаар би түрүүн нөгөө хэлээд байгаа ажлаа хийж байгаа төрийн албан хаагчдыг дарамтлах, ёс зүйгүй аашлах, иргэдийн юм уу, танхай балмад этгээдүүд бас ажлын байран дээр нь дарамталдаг янз бүрийн юм байна шүү дээ.

Энэ хүмүүсээ бас хамгаалах тал дээр бас нэг жаахан анхаарч ажиллахгүй бол арай болмооргүй байна.

Тэр ажлаас халагдаж байгаа хүмүүсийг тэр цалин хөлсийг нь нөхөн төлүүлдэг юман дээр жаахан зовлон байна гэж түрүүн ярилаа шүү дээ. Төрийн албаны зөвлөлийн гишүүн хариултад. Тэрийгээ одоо энэ хуулиудын юман дээр шаардлагатай бол Байнгын хороотойгоо яриад, хуульд нь өөрчлөлт. Яг ямар гацаа саад байгаа юм гэдэг дээр Та бүхэн нэг юмнууд оруулаад ирээч.

Тэгээд л аяндаа яг хуулийг хэрэгжүүлдэг болгоод эхлэх юм бол наана чинь тэгж хууль бусаар халахаасаа айж болгоомжилдог болоод л эхэлчих юм л гэж би хараад байгаа юм л даа.

Дараагийн нэг асуудал. Энэ төрийн албан хаагчдыг сургаж дадлагажуулах юман дээр би өчигдөр бас санал хэлсэн. Тийм ээ. Энэ Удирдлагын академид Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт Та бүхэн нэг ажиллаад үүнийг бүр тогтворжуулмаар санагдаад байгаа байхгүй юу. Энэ төрийн албан хаагчдыг

сургаж дадлагажуулж. Та бүхний тайланд байна. Тэгэхдээ яг бодитой юм бол алга.

Яг тогтмолжуулаад. Төрийн жинхэнэ албан хаагчийг нэг жил, таван жил, арван жил байдаг юм уу сургадаг. Тэр сургалтыг дүүргэсэн бол цаашаа ажиллах тэр сертификат гэдэг юм уу, ажиллах жилийн сунгадаг ч байдаг юм уу, тэр сургалтдаа суугаагүй, шалгалтаа өгч чадаагүй бол тушаал зэрэглэл бууруулдаг юм уу. Ийм нэг юмаар жаахан механизм, хөшүүрэг хийхгүй бол нэг ажлын байран дээр ер нь ялзарчих гээд байна шүү. Хөдөө орон нутагт.

Ж.Мөнхбат: Минут сунгаж өгье. Ё.Баатарбилэг гишүүнд.

Ё.Баатарбилэг: Тэгэхээр энэ ингэж сургаж дадлагажуулах юман дээр үнэхээр төсөв, санхүүгийн боломж болохгүй байгаа юм уу, ямар юм байгаа юм. Энэ дээр Та бүхэн нэг санал бэлдээд өгөөдөхөөч.

Байнгын хорооны дарга хэлсэн шүү дээ. Төрийн албаны зөвлөлийн тэр төсөв, санхүү дээр эргэж харах юмнууд байгаа бол. Түүндээ яг энэ сургалттай холбоотой, академитай холбоотой юм байвал нэг бодооч.

Энэ төрийн тусгай албан хаагчдын асуудлыг нэг эргэж харах нь зөв. Төрийн албаны хууль чинь ерөнхий суурь зарчим явж байгаа шүү дээ. Тэр салбар хуулиуд бол Төрийн албаны хуульдаа захирагдсан салбарын тэр ёс зүй, сахилга хариуцлага, бүх юм нь энэ төрийн албаныхаа хуульд зангидагдаж явах ёстой шүү дээ.

Төрийн албаныхаа хуулийг давчихсан салбарын тэр дотоод салбарын төрийн албан хаагчдаа тусгай албан хаагчдыг журамласан тийм хууль, дүрэм гэж байх ёсгүй. Үнэхээр тийм Төрийн албаны хуулийг давчихсан тийм салбарын юмнууд байвал Та бүхэн нэг хараач.

Үнэхээр заримдаа бол бас нэлээн тийм ойлгомжгүй юмнууд харагдаад байгаа шүү. Нэг ийм хэдэн зүйл дээр Та бүхэн маань нэг ажиллаадахаач... /минут дуусав/

Ж.Мөнхбат: Цахимаар Нямаагийн Энхболд гишүүн үг хэлнэ.

Н.Энхболд: Төрийн албаны зөвлөлийн тайланг сонслоо. Төрийн албаныхан миний оролцоотой, миний мэдэж байгаагаар хоёр удаа ингэж шинэчлэгдэж батлагдаж байгаа юм. Төрийн албаны зөвлөл бол нэлээн сүүлд байгуулагдсан байгууллагын нэг.

Ерөөсөө энэ хууль, энэ зүйл хоёрын хамгийн гол зорилго нь бол Монгол Улсын төрийн ажлыг мэргэжлийн хүмүүсээр үнэнч шударгаар, хууль зөрчихгүйгээр хийлгэхэд чиглэсэн, улс төрөөс ангид байх маш том зорилготой ийм л хуулиуд байгаа. Ялангуяа сүүлийн Төрийн албаны хууль бол өмнөхтэй нь харьцуулахад зарим хүнд бол нэлээн тийм хатуу чанга юм шиг санагдсан заалтуудтай. Гэхдээ тэгэхээс өөр аргагүй нөхцөл байдал үүсчихсэн үед үүнийг хийсэн.

Одоо ингээд тэр үед нь өөр юм ярьж байсан улсууд одоо болохоор бас өөр юм яриад л байдаг юм. Одоо Төрийн албаны хууль тийм байхад тэгж байсан. Одоо энэ болохоор ингээд байна. Үүнийгээ мөрдөхгүй байна гээд.

Тэгэхдээ эцсийн дүнд миний ажиглаж байгаагаар энэ чинь алхам алмаар бас ахиц гараад байгаа юм. Энэ сүүлд сонгогдоод ажиллаж байгаа Төрийн албаны зүйл бас нэлээн тийм туршлагатай хүмүүсээр. Надад ойлгогдсоноор болж өгвөл хуулиа аль болохоор шахаад, улс төрөөс ангид байх юм сан гэсэн ийм бодлого гарч байгаа. Би бас муугүй ажиллаж байгаа Төрийн албаны зөвлөл гэж ингэж бодож байгаа.

Тэгэхээр энэ чиглэлээ цаашид сайн бариарай. Сая Ё.Баатарбилэг гишүүн миний бодож байсан хоёр гурван юмыг хэлчихлээ. Би давхардуулаад яах вэ. Зүгээр тэр хууль бусаар халагдаж байгаа улсуудтай гомдол, чирэгдлийн асуудлыг шийдэхэд болохгүй байгаа хууль тогтоомжуудын талаар санал онолоо Төрийн албаны зүгээс яг ийм хуулийн ийм зүйлүүд нь энэ том хуульдаа тавьсан зорилгоо хэрэгжүүлэхэд саад болоод байна гэсэн саналуудаа түргэн түргэн өгөөд байвал манай Байнгын хороо тэрийг нь аваад шуурхай шуурхай хэлэлцээд асуудал шийдвэрлэдэг зохицуулалтуудыг нь хурдавчлаад өгөх ийм боломжууд байгаа. Ийм хүсэл эрмэлзэл ч байгааг би хэлье.

Сүүлд нь улс төрөөс ангид байх юм дээрээ бол бас зоригтой байгаарай. Янз бүрийн улс төрийн шалтгаантай дарамтууд, хүн амьтны хойноос нь гүйсэн хөөцөлдсөн. Наадах чинь болохгүй, тэгнэ ингэнэ гэсэн юмнууд ирдэг.

Тэгэхээр тэгж ярьж явж байгаа улсууд байвал наадах чинь ингээд ингээд энэ хуультай зөрчилдөөд байна гээд. Тэгээд тэрийг өөр ямар нэгэн байдлаар Төрийн албаны зөвлөлийн байр суурь, хуулийг давж гарах гэсэн оролдлогууд хийгээд байвал тэрийг шууд Байнгын хороон дээр мэдээлж байх хэрэгтэй.

Та нар Улсын Их Хурлын мэдлийн байгууллага, гол нь доор нь ажил зохицуулж байдаг байгууллага нь манай Төрийн байгуулалтын байнгын хороо. Байнгын хороогоороо дамжуулаад тийм улс төрчдийн, тийм албан тушаалтан Төрийн албаны зөвлөл Төрийн албаны хуулийг зөрчүүлэх ийм шаардлага тавиад ийм дарамт шахалт үзүүлээд байна гэсэн юм гарвал тэрийг нь эхлээд өөрт нь мэдээж сануулах хэрэгтэй. Наадах чинь болохгүй. Ийм шүү гээд. Тэгээд зогсохгүй байвал Төрийн байгуулалтын байнгын хороогоороо дамжуулаад тийм тийм зүйлүүдийг л нэг хоёр жишээн дээр л таслан зогсоогоод, олон нийтэд мэдэгдээд орхивол тэгээд дахиад тийм юм гаргах боломжууд нь хаагдаад харагдаад ирнэ шүү дээ.

Тэгээд тэндээс сайн анхаараарай гэж хэлье. Тэгээд ажилд нь амжилт хүсье. Манай байнгын хорооноос янз бүрийн тогтоол шийдвэр юм гарахгүй юм байна гэж ойлголоо.

Ер нь хэлэлцсэнийхээ дагуу Байнгын хорооноос нэг чиглэл гаргаад, би тийм чиглэл дээр гишүүдийн ярьж байгаа зүйлүүд дээр анхаарч санал онол боловсруулж ирээрэй гэсэн ийм чиглэлийг Төрийн албаны зөвлөлдөө өгөх ийм хууль зүйн хаалга нээлттэй байгаа гэж ойлгож байна. Энэ дээр бас Байнгын хороон дарга анхаарна байх гэж найдаж байна. Ингээд та бүхэнд амжилт хүсье.

Ж.Мөнхбат: Н.Энхболд гишүүний ярьж байгаа саяын хөндөж байгаа асуудал бол маш чухал шүү.

Манай Төрийн албаны зөвлөлийнхөн анхааралдаа авч ажиллаарай.

Нэгдүгээрт, Төрийн албаны зөвлөл Улсын Их Хурлаас томилогддог. Улсын Их Хурлын хяналтыг хэрэгжүүлдэг ийм байгууллага. Тийм учраас Төрийн албаны

хууль зөрчигдөж байгаа, улс төрийн нөлөөлөл орж байгаа ийм асуудлаар. Хууль зөрчиж ямар нэгэн томилгоо хийгдэж байгаа энэ асуудал дээр бол Төрийн албаны зөвлөл нэлээн чангахан ажиллах хэрэгтэй. Бүрэн эрх чинь байгаа. Төрийн албаны хуулиар нээж өгсөн.

Төрийн албыг тогтвортой байлгах туршлага, ур чадвар, мерит зарчим дээр тулгуурладаг болох, шатлан дэвжих, улс төрөөс ангид байх асуудал нээлттэй байгаа. Манай Төрийн албаны зөвлөл дөрөв, таван том эрх энэ Төрийн албаны хуулиар нээгдсэн шүү дээ. Зөвхөн төрийн албан хаагчдыг сонгон шалгаруулдаг биш. Зөвлөмж, арга зүйн зөвлөгөө өгдөг, хяналт шалгалт тавьдаг, хууль зөрчигдсөн бол, алдаа гаргасан бол хариуцлага тооцох асуудлыг хөнддөг энэ бүрэн эрх байгаа.

Тийм учраас энэ хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлж, ажиллаарай. Хэрэгжүүлж ажиллаарай. Сүүлийн үед бол. Яах вэ, одоо энэ дэлхий нийтээрээ цар тахлын ийм нөхцөл байдалтай байгаа амаргүй үеийг зөвхөн Монгол Улс биш дэлхий нийтээрээ туулж байна.

Гэхдээ үүнийг далимдуулж хэт дураараа авирлаж байгаа дарга, сайд нар байгаа шүү. Эд нар дээр Та бүхэн ажиллаж. Сая Нямаагийн Энхболд гишүүний хэлдэг тэр асуудлыг нь Их Хурал, Байнгын хороондоо оруулж ирэх, танилцуулах, асуудлыг нь хөндөх. Өөрөөр хэлэх юм бол хууль зөрчиж ингэж томилгоо хийж байгаа энэ асуудлыг нь. Ийм ийм зүйлийг цаашдаа манай Төрийн албаны зөвлөл анхааралдаа авч ажиллаарай гэдгийг хэлье гэж бодож байна.

Сая Н.Энхболд гишүүний ярьснаар хяналт шалгалтын хууль ингээд батлагдах юм бол Төрийн албаны зөвлөл өөрөө томилгооны сонсгол хийгддэг болно. Төрийн албаны зөвлөлийн гишүүд.

Одоо бол Төрийн албаны зөвлөл Төрийн байгуулалтын байнгын хороон дээр ажлынхаа тайланг тавьж байгаа. Энэ хууль батлагдах юм бол Төрийн байгуулалтын байнгын хороон дээр ажлын тайлангаа тавина. Нэгдсэн чуулган дээр тавина. Улсын Их Хурлын. Ийм болж өөрчлөгдөх юм.

Тийм учраас хяналтын, шалгалтын ажил ингээд нэлээн өндөр түвшинд яригдахаар болж байгаа шүү. Ё.Баатарбилэг гишүүн Төрийн албаны хуульд өөрчлөлт оруулах гурван гол зарчим, тэр ажилласан хугацааг дүйцүүлэх. Сонгон шалгаруулалтыг жилд нэг удаа биш хоёр. Бүр улирал тутамд явуулах. Нэг удаа улирал тутамд. Авлигатай тэмцэх газраас төрийн албанд томилогдоход бичиг авч байгаа. Тийм үү. Ашиг сонирхлын зөрчилтэй эсэхийг.

Тэгэхээр тэр бичиг сүүлдээ ашиг сонирхлын зөрчилтэй эсэхийг биш одоо бүр янз янзын юм бичдэг ийм болсон юм билээ. Тэгээд үүнийг хязгаарлах ийм хуулийн зохицуулалтууд орж ирж байгаа.

Ё.Баатарбилэг гишүүн түрүүн яриад байна лээ. Тусгай чиг үүргийн төрийн алба байна шүү дээ. Төрийн тусгай алба. Тэгээд энэ дээр намар Төрийн байгуулалтын байнгын хорооноос ер нь энэ Төрийн албаны хууль хаана, хэрхэн зөрчигдөж байна. Хэр хэрэгжиж байна гэдгийг яам, Тамгын газрууд, холбогдох гол байгууллагууд дээгүүр ажлын хэсэг гаргана. Төрийн байгуулалтын байнгын хорооноос хоёр ажлын хэсэг гарна. Нэг нь Төрийн албаны хуулийн хэрэгжилттэй холбоотой.

Хоёрдугаарт, энэ төрийн тусгай албаны томилгоо. Үүнтэй холбоотой бас ажлын хэсэг гарна гэж ингэж Та бүхэн маань ойлгоорой.

Хэдийгээр энэ томилгоонууд тодорхой чиг үүргийн чиглэлийн хуулиудаар зохицуулагддаг ч гэсэн өөрөө төрийн албаныхаа үндсэн энэ том хуульд нийцэж байх ёстой. Тийм биз. Тийм учраас Та бүхэн маань энэ бүхнийг бодож, Монгол Улсад иргэддээ төрийг төлөөлж ажиллаж байгаа энэ бүх хүмүүс хэр ажиллаж байна вэ. Зөв байна уу, буруу байна уу, хууль зөрчиж байна уу, зөрчихгүй байна уу. Улс төрийн сайд нар, улс төрийн албан тушаалтнууд, Засаг дарга нар, шат шатны. Энэ хүмүүс хэр төрийн албыг улс төрийн алба болгох, эсвэл Төрийн албаны хуулийг зөрчиж ажиллаж байгаа. Энэ дээр Та бүхэн сайн ажиллах ёстой.

Тэр улс төрийн юугаар ажлаас халагдаж байгаа хүмүүс дээр Та бүхэн ирж байгаа гомдол, санал дээр нь шуурхай арга хэмжээ авч байгаарай.

Энэ талаараа Төрийн байгуулалтын байнгын хороонд ийм, ийм асуудал дээр ингэж ингэж шийдвэрлэлээ гэдэг энэ зүйлийг Та бүхэн тайлангаа бас ирүүлж байгаарай. Сар тутам. Тийм. Байнгын хороотойгоо сайн хамтарч ажиллана. Их Хуралтайгаа хамтарч ажиллана шүү. Ийм ийм зүйлийг Та бүхэндээ хэлье.

Тэгээд би Төрийн албаны зөвлөл маань бас сайн ажиллаж байгаа. Төрийн албаны зөвлөлийн гишүүд бол одоо манай С.Цэдэндамбаа гишүүн, Д.Зүмбэрэллхам гишүүн, Б.Идэрчулуун гишүүн, Б.Баатарсайхан гээд олон жил энд ажилласан туршлагатай дадлагатай ийм хүмүүс байгаа. Мэргэшсэн гэж хэлж болохоор ийм хүмүүс байгаа.

Би зарим дарга нарыг нь танихгүй юм. Одоо манай Ж.Жамъянтив даргаас авхуулаад бас энэ төрийн албанд зүтгэсэн. Насаараа зүтгэсэн. Энэ алдаа оноо, зам мөрийг нь туулсан ийм туршлагатай хүмүүс байж байна.

Манай Б.Баатарзориг дарга бол Төрийн албаны зөвлөл сайн удирдаж ажиллаж байгаа гэж Байнгын хорооны даргын хувьд үзэж байгаа.

Тэгэхдээ ялангуяа хууль зөрчиж ажлаас нь халж байгаа, улс төрийн зорилгоор л халж байгаа энэ асуудлууд дээр. Их Хурал дээр ирж байгаа асуудлуудыг танайх руу шилжүүлж байгаа. Албан тоотоор бид. Тийм ээ. Энэ асуудлууд дээр Та нар анхаарал тавьж, эргэж хариугаа мэдэгдэж, ингэж ажиллаарай гэдгийг энэ дашрамд хэлье гэж бодож байна.

Ингээд Төрийн албаны зөвлөлийн 2019, 2020 оны үйл ажиллагааны тайлан хэлэлцэж дууслаа. Төрийн албаны дарга, зөвлөлийн гишүүд, ажлын албанд баярлалаа.

Төрийн байгуулалтын байнгын хорооны хэлэлцэх асуудал дууссан тул энэ өдрийн хуралдаан хаасныг мэдэгдье. Байнгын хорооны гишүүддээ баярлалаа.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД